


# БОДЛОГЫН ТОВЧООН

## POLICY BRIEF

ᠪᠣᠳᠯᠣᠭᠢᠨ ᠲᠣᠪᠴᠣᠨ



ПАРЛАМЕНТЫН БОЛОН  
БАЙНГЫН ХОРООДЫН  
ХУРАЛДААНЫГ АЛСЫН  
ЗАЙНААС ЯВУУЛЖ САНАЛ  
ХУРААХ ТАЛААРХ ЗАРИМ  
ОРНЫ ТУРШЛАГА

ПАРЛАМЕНТЫН БОЛОН  
БАЙНГЫН ХОРООДЫН  
ХУРАЛДААНЫГ ЕРДИЙН  
ГОРИМООР ЯВУУЛЖ БАЙГАА  
ЗАРИМ ОРНЫ ХЭРЭГЖҮҮЛЖ  
БУЙ ТУРШЛАГА

СОНГУУЛЬД ҮЗҮҮЛЭХ  
НӨЛӨӨ

### **1. КОРОНАВИРУСНИЙ ХАЛДВАРЫН ДЭГДЭЛТИЙН ҮЕ ДЭХ ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ПАРЛАМЕНТЫН АЖИЛЛАГАА** /2020 оны 4 дүгээр сарын 01–ний өдрийн байдлаар/

### **2. ПАРЛАМЕНТЫН БОЛОН БАЙНГЫН ХОРООДЫН ХУРАЛДААНЫГ АЛСЫН ЗАЙНААС ЯВУУЛЖ САНАЛ ХУРААХ ТАЛААРХ ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА**

- 2.1 Евро Парламент
- 2.2 Австралийн Холбооны Улс
- 2.3 АНУ–ын Пенсильвани муж
- 2.4 Холбооны Бүгд Найрамдах Герман Улс
- 2.5 Шинэ Зеланд Улс
- 2.6 Бүгд Найрамдах Польш Улс
- 2.7 Люксембургийн Их Гүнт Улс
- 2.8 Холбооны Бүгд Найрамдах Бразил Улс
- 2.9 Испанийн Хаант Улс

### **3. ПАРЛАМЕНТЫН БОЛОН БАЙНГЫН ХОРООДЫН ХУРАЛДААНЫГ ЕРДИЙН ГОРИМООР ЯВУУЛЖ БАЙГАА ЗАРИМ ОРНЫ ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ ТУРШЛАГА**

- 3.1 Бельгийн Хаант Улс
- 3.2 Нидерландын Хаант Улс
- 3.3 Финланд
- 3.4 Австри
- 3.5 Шведийн Хаант Улс
- 3.6 Данийн Хаант Улс
- 3.7 Норвегийн Хаант Улс

### **Хүснэгт 1. КОРОНАВИРУСНИЙ ХАЛДВАРЫН ДЭГДЭЛТИЙН ҮЕ ДЭХ ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ПАРЛАМЕНТЫН АЖИЛЛАГАА** /2020 оны 4 дүгээр сарын 01–ний өдрийн байдлаар/

#### **4. СОНГУУЛЬД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ**

**Хүснэгт 2. COVID–19–ийн дэгдэлтийн улмаас сонгуулиа хойшлуулсан орнууд**

**Хүснэгт 3. Сонгуулиа 2020 оны 3 дугаар сард зохион байгуулсан орнууд**

**Хүснэгт 4. Сонгуулиа товолсон хугацаандаа зохион байгуулах орнууд**

**Хүснэгт 5. Сонгуулийн үед COVID–19–ийн дэгдэлтээс урьдчилан сэргийлэхээр авсан, эсхүл авах хэмжээ**

#### **Хавсралт 1. БРАЗИЛИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ТАНХИМЫН ТОГТООЛ (№14, 2020)**

## **1.КОРОНАВИРУСНИЙ ХАЛДВАРЫН ДЭГДЭЛТИЙН ҮЕ ДЭХ ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ПАРЛАМЕНТЫН АЖИЛЛАГАА**

/2020 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар/

Дэлхий дахинд коронавирусний халдварын дэгдэлт хурдацтай тархаж буй одоогийн нөхцөлд улс орнуудын парламентын үйл ажиллагаанд дараах өөрчлөлтүүд орж байна. Үүнд:

- **Нэгдсэн болон байнгын хороодын хуралдааныг тодорхой, эсхүл тодорхой бус хугацаагаар хойшлуулсан, зогсоосон:** Хятад, Иран, Филиппин, Кени, Непал, Ботсван, Герман, Швейцар, Польш, Франц, Канад, Лихтенштейн, Болгар, Пакистан, Өмнөд Африк, Австрали, Хятад, Иран зэрэг орнууд хэрэгжүүлж байна.
- **Нэгдсэн болон байнгын хороодын хуралдааны тоог цөөлж багасгасан:** Евро Парламент, Эстони, Итали, Шинэ Зеланд, Нидерланд, Австри, Франц, Албани, Финланд, Герман, Хорват, Швед, Дани зэрэг орнууд хэрэгжүүлж байна.
- **Зөвхөн онц шуурхай асуудлаар хуралдахаар болсон:** Пакистан, Филиппин, Канад, Албани, Болгар, Франц, Эстони, Итали, Хорват, Дани зэрэг орнууд хэрэгжүүлж байна.
- **Хуралдаан явуулах байршлыг эрсдэл бага газар луу шилжүүлсэн:** Евро Парламент, Хорват (газар хөдлөлтийн улмаас) зэрэг орнууд хэрэгжүүлж байна.
- **Хуралдаанд оролцох гишүүдийн дээд хязгаарыг тогтоосон:** Франц, Канад, Герман, Шинэ Зеланд, Финланд, Норвеги, Их Британи, Хорват, Герман, Швед зэрэг орнууд хэрэгжүүлж байна.
- **Гишүүдийн суудал хоорондын зохистой зайг (1м, 1,5м, 2м) тогтоосон:** Шинэ Зеланд, Хорват, Герман, Финланд, Австри, Итали, Норвеги орно.
- **Олон нийтийг хамарсан арга хэмжээг хойшлуулсан, цуцалсан:** Евро Парламент, Австрали, Япон, Их Британи, Шинэ Зеланд зэрэг орнууд хэрэгжүүлж байна.
- **Парламентын ордонд нэвтрэх хязгаарлалт тогтоосон:** Австрали, Их Британи, Нидерланд, Франц, Шинэ Зеланд, Норвеги, Япон зэрэг орнууд хэрэгжүүлж байна.
- **Алсын зайнаас ажиллахаар болсон:**<sup>1</sup> Евро Парламент, Испани, Ливан, Бразил, Өмнөд Африк, Польш зэрэг орнуудын парламент нэгдсэн болон хороодын хуралдаанаа, харин Люксембург, Албани, Бахрейн, Австрали, Их Британи зэрэг

<sup>1</sup> **“Remote participation” болон “Teleworking” ойлголтын талаар:**

Европын Парламентын хувьд 2020 оны 3-р сарын 19-нд Ерөнхий нарийн бичгийн дарга Парламентын ажлын албанд гишүүдийг хуралдаанд алсын зайнаас оролцох боломжоор хангаж, бэлтгэл ажил хийхийг үүрэг болгосон. Европын Парламентын Ерөнхий нарийн бичгийн даргын гарын үсэг зурсан баримтад: **“remote participation”** буюу алсын зайнаас оролцох гэдэг нь *“being able to view and listen to proceedings, ask for the floor and intervene in the meeting”* буюу “хуралдааныг үзэж, сонсох, асуулт асууж, үг хэлж хуралд оролцох”-ыг ойлгоно гэжээ.

Мөн “гишүүд өөрсдийн iPad, эсхүл iPhone-г ашиглан платформд алсаас холбогдох боломжтой” гэж баримт бичигт дурджээ. Дээрх платформ нь нийт 1000 оролцогчийн оролцоог хангаж, **“remote polling”** буюу алсын зайн санал хураалт явуулах боломжтой юм.

орнууд зөвхөн байнгын хороодын хуралдаанаа зайнаас явуулахаар болсон. Украин, Эстони, Замби, Итали, Ливан зэрэг орнууд энэ талаар судалж байна.

(Хүснэгт 1-ээс дэлгэрүүлж үзнэ үү.)

COVID-19 вирусний цар тахал дэгдсэнтэй холбогдуулан дэлхийн улсуудын парламентын байнгын ажиллагаа тасалдахад хүрч байна. Үүнтэй холбоотой улс оронд шаардлагатай яаралтай асуудлыг парламентаар хэлэлцүүлж батлах процессыг хэрхэн явуулах талаарх санал санаачилгыг парламентын гишүүд болон олон нийтээс гаргаж байна.

Хэдийгээр одоо байгаа *online-conference* эсхүл, *video-conference* системийг ашиглан зайнаас цахим хэлбэрээр парламентын хуралдааныг тогтмол явуулах талаар санал гаргаж байгаа боловч одоогийн байдлаар нэгдсэн шийдвэрт хүрээгүй байна.

Харин яаралтай хууль тогтоомжийг алсын зайнаас санал хураах замаар батлахаар шийдэж буй цөөн хэдэн тохиолдол байна. Гэхдээ энэ тохиолдолд парламентын хуралдааны дэг, гишүүдийн асуулт, хариулт хэрхэн явагдах, саналын нууцлалын асуудлыг хэрхэн шийдэх нь нарийн зохицуулагдаагүй байна.

## **2. ПАРЛАМЕНТЫН БОЛОН БАЙНГЫН ХОРООДЫН ХУРАЛДААНЫГ АЛСЫН ЗАЙНААС ЯВУУЛЖ САНАЛ ХУРААХ ТАЛААРХ ЗАРИМ ОРНЫ ТУРШЛАГА**

Одоогийн нөхцөлд зарим орны парламентаас хэрэгжүүлж буй зайнаас хуралдаж, санал хураалт явуулах туршлагын талаар тоймлон хүргэвэл:

1. Евро Парламентын хуралдааныг 2020 оны 3-р сарын 26-ны өдөр зайнаас явуулж, цахим шуудангаар санал хураалт явуулахаар шийдвэрлэсэн байна.
2. Австралийн Холбооны Улс. Парламентын чуулганыг 2020 оны 8-р сарын 11 хүртэл хойшлуулсан. Харин Хороодын үйл ажиллагааг зайнаас явуулхаар шийдвэрлэсэн.
3. АНУ-ын Пенсильвани мужийн Төлөөлөгчдийн танхим нь COVID-19 вирусний дэгдэлттэй холбоотой онц байдлын үед хэрэгжүүлэх Төлөөлөгчдийн танхимын түр журмыг 2020 оны 3-р сарын 16-нд баталсан байна.
4. Холбооны Бүгд Найрамдах Герман Улс. Нэгдсэн фракци нь 2020 оны 3-р сарын 23-нд төлөвлөөд байгаа фракцийн хурлаа фракцийн гишүүдийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх үүднээс тэргүүлэх депутатууд, Засгийн газрын төлөөлөгчдийг хамруулан зайнаас зохион байгуулахаар шийдвэрлэв.
5. Шинэ Зеланд Улс. Парламентын Бизнесийн хороо нь Танхимын санал хураалтад оролцох хүмүүсийн тоог багасгах зорилгоор зарим үйл ажиллагааг (хорооны хуралдаан, асуулт асуух, санал өгөх) цахим хэлбэрээр явуулахыг дэмжиж журмын төсөл боловсруулсан.
6. Бүгд Найрамдах Польш Улс. Сейм Танхимын хуралдааны дэгд өөрчлөлт оруулах саналыг дэмжсэн. Танхимд байх гишүүдийн тоог хязгаарласан бөгөөд хуралдаанд намын бүлгийн төлөөлөгч нар оролцож, бусад гишүүд алсын зайнаас оролцох юм.

7. Люксембургийн Их Гүнт Улс. Парламентын хуралдаан ердийн горимоор явагдаж байгаа бөгөөд Байнгын хороодын хуралдааныг видео хэлбэрээр зохион байгуулж байна.
8. Холбооны Бүгд Найрамдах Бразил Улс. Парламент нэгдсэн хуралдааныг виртуал хэлбэрээр явуулахтай холбогдох хуулийг баталсан бөгөөд Сенат анхны виртуал хэлбэрийн хуралдаанаа явуулжээ.
9. Испанийн Хаант Улс. Парламент хуралдааныг зайнаас явуулахтай холбоотой шинэ хуулиа яаралтай баталсан бөгөөд нэгдсэн хуралдааныг виртуал хэлбэрээр явуулж эхэлсэн.

## 2.1. ЕВРОПЫН ПАРЛАМЕНТ



*2020 оны 3-р сарын 26-ны өдөр Европын Парламент цахимаар хуралдаж зайнаас санал хураалт явуулав.*

Европын парламентын байршлыг өөрчилж Францын Страсбург хотоос Бельгийн нийслэл Брюссель рүү шилжүүлсэн.

2020 оны 3-р сарын 11-нээс Европын парламентын ажлын албаны дийлэнх ажилтнууд зайнаас буюу teleworking ажлын горимд шилжсэнтэй холбоотой парламентын гишүүд нийтээрээ зайнаас ажиллах шийдвэрт хүрсэн байна.

Европын парламентын ерөнхийлөгч болон улс төрийн бүлгийн тэргүүлэгчид зөвлөлдөөд Европын парламентын ерөнхийлөгчийн саналыг дэмжин 2020 оны 3-р

сарын 26-нд ээлжит бус чуулганыг товлон хуралдуулж яаралтай арга хэмжээ авах шийдэлд хүрсэн байна.

2020 оны 3-р сарын 26-нд Covid-19 халдварын улмаас гишүүн орнуудад туслах яаралтай арга хэмжээний талаар цахимаар<sup>2</sup> (видео хурал) явагдах ээлжит бус



чуулганы санал хураалтыг хэрхэн явуулах тухай нэлээд хэлэлцсэний эцэст Европын парламентын ажлын албанаас Сонгуулийн тухай болон Гишүүний тухай хуульд заасны дагуу гишүүний санал найдвартай, аюулгүй байх нөхцөлийг бүрдүүлж, гишүүдийн парламентын цахим хаягийг ашиглан саналыг хүлээж

авахаар шийдэлд хүрсэн байна. Гишүүн өөрийн парламентын цахим шуудангаар саналын хуудсыг хүлээн авч бөглөөд, буцааж илгээнэ. Гишүүдийн илгээсэн саналыг хурлын тэмдэглэлд тэмдэглэнэ. Ийнхүү 2020 оны 7-р сарын 31 хүртэл санал хураалтыг цахимаар явуулахаар шийдвэрлэсэн байна.<sup>3</sup> Хороодын хуралдааныг тодорхойгүй хугацаагаар хойшлуулсан хэвээр байна.<sup>4</sup>

Хуралдааныг цахимаар явуулж зайнаас санал хураах ажлын хүрээнд дараах арга хэмжээг хэрэгжүүлж байна. Үүнд:

- Цахим шуудангаар явуулж буй албан бичигт биечлэн гарын үсэг зурж байгаа хэдий ч энэ нь өөрчлөгдөж магадгүй.
- Ажлын албаны ихэнх албан хаагчид зайнаас ажиллаж байна.
- Мэдээлэл технологийн алба нь маш ачаалалтай ажиллаж байна.
- Interactio, Kudo зэрэг шууд цахим орчуулгын платформыг туршиж үзсэн боловч шаардлага хангахгүй тул өөрсдөө орчуулгаа хийж түүнийгээ цахимаар илгээж байна.
- Чуулганд зайлшгүй шаардлагатай цөөн тооны гишүүд биечлэн оролцох ба бусад гишүүд цахим сүлжээгээр видео хэлбэрээр холбогдон оролцох шинэ систем рүү шилжихээр шийдвэрлэж байна.
- Одоогийн байдлаар дотоод журамдаа зарим гишүүд биечлэн, зарим гишүүд алсын зайнаас оролцох өөрчлөлтийг хийгээд байна.
- Санал хураалтыг алсын зайнаас цахим байдлаар явуулах бөгөөд санал хураалтын жагсаалт, саналын хуудас, санал хураалт эхлэх болон дуусах тодорхой хугацааг гишүүн бүрт цахим шуудангаар хүргүүлнэ. Гишүүд саналын хуудсанд гарын үсгээ зурж, сканнердаад, саналын хуудасны цахим хуулбарыг цахим шуудангаар эргүүлэн илгээнэ.

<sup>2</sup> [https://multimedia.europarl.europa.eu/en/plenary-session\\_20200326-0900-PLenary\\_vd](https://multimedia.europarl.europa.eu/en/plenary-session_20200326-0900-PLenary_vd)

<sup>3</sup> <https://techcrunch.com/2020/03/23/eu-parliament-moves-to-email-voting-during-covid-19/>

<sup>4</sup> <https://www.europarl.europa.eu/committees/en/home>

## 2.2. АВСТРАЛИЙН ХОЛБООНЫ УЛС

COVID-19-ийн нөхцөл байдалтай холбогдуулан парламентын чуулганыг 2020 оны 8-р сарын 11 хүртэл хойшлуулсан бөгөөд 5-р сард баталдаг төсвийг 2020 оны 10-р сарын 6-нд батлахаар болоод байна. Харин Хороодын үйл ажиллагаа алсын зайнаас явагдана.

Парламентын чуулганы хуралдааныг хойшлуулсан ч үүсээд буй нөхцөл байдалтай холбоотойгоор холбогдох хууль, дүрмийн хүрээнд Хороодын үйл ажиллагааг зайнаас явуулах боломжтой юм. Тухайлбал, Төлөөлөгчдийн танхимын хуралдааны дэгийн 235 (b)-д: *“Хорооны үйл ажиллагааг хорооны гишүүд, эсхүл гэрч нартай дуу-дүрсний (audio visual), эсхүл аудио холболт (audio links)-ыг ашиглан явуулж болно. Дуу-дүрс, эсхүл аудио холболтыг ашиглаж буй тохиолдолд хорооны гишүүд, гэрчүүд хаана байхаас үл хамааран бие биетэйгээ нэгэн зэрэг ярих, сонсох боломжтой байх ёстой”* гэж заасан.

Сенатын хуралдааны дэгийн 30-д Сенатын хороодын хуралдааныг цахим хэлбэрээр явуулахыг зөвшөөрсөн бөгөөд оролцогчид нь нэг дор байрлах шаардлагагүй юм.

Харин хүчин төгөлдөр үйлчилж буй Үндсэн хуульд (1901 он) Парламентын хууль тогтоох ажиллагаанд "шуудан, телеграф, телефон утас болон бусад адил төстэй үйлчилгээ"-г ашиглаж болохыг заасан бөгөөд үүнд радио, телевиз, интернет зэрэг технологийн дэвшилтэд бусад арга хэрэгслүүд багтаж болно гэж тайлбарлаж байгаа юм. Үндсэн хуульд Парламентын хуралдаан явагдах газар (байршил – Австралийн Нийслэлийн Нутаг дэвсгэр), гишүүдийн ирц (гуравны нэгээс доошгүй) зэргийг заасан учир алсын зайнаас ажиллахад хүндрэл үүсэх юм. Үүнтэй холбоотойгоор 2020 оны 3-р сарын 23-нд Ерөнхий Атторней Кристиан Портер хоёр санал оруулсан бөгөөд энэ нь спикер болон томоохон намууд зөвшөөрсөн тохиолдолд гишүүд зайнаас оролцох, мөн хоёр том нам зөвшөөрсөн тохиолдолд хуралдааныг дэгт өөрчлөлт оруулахад дийлэнх олонхын саналыг шаардахгүй зэрэг боломжуудыг нээж өгөх юм.<sup>5</sup>



<sup>5</sup><https://theconversation.com/a-virtual-australian-parliament-is-possible-and-may-be-needed-during-the-coronavirus-pandemic-134540?fbclid=IwAR26ORiohuCu9zQl1C2YwtyDWiKSOI5B5z7brWPqacY6xVXIbCGJzyq0n4>

## 2.3. АНУ-ЫН ПЕНСИЛЬВАНИ МУЖ



*АНУ-ын Пенсильвани муж улсын Сенат 2020 оны 3-р сарын 25-ны өдөр хуралдаанаа онлайнаар зохион байгуулж, зайнаас санал хураалт явуулав.*

АНУ-ын Пенсильвани мужийн Төлөөлөгчдийн танхим нь COVID-19 вирусний дэгдэлттэй холбоотой онц байдлын үед хэрэгжүүлэх Төлөөлөгчдийн танхимын түр журам баталсан байна. Журамд тусгасан асуудлыг тоймолбол:<sup>6</sup>

- Төлөөлөгчдийн танхимын гишүүд нь заавал хуралдааны танхимд байлгүйгээр зайнаас санал өгч болно. Үүний тулд гишүүн нь тухайн хэлэлцэж буй асуудлаар ямар саналтай байгаагаа бүлгийнхээ зохицуулагчид (whip) урьдчилан мэдэгдэнэ. Бүлгийн зохицуулагч нь гишүүний хэлсний дагуу хуралдааны танхимд гишүүний өмнөөс санал өгнө. Хуралдааны танхимд зөвхөн Хурлын дарга, бүлгийн ахлагчид, бүлгийн зохицуулагчид эсхүл, итгэмжлэгдсэн төлөөлөгч мөн заавал оролцох шаардлагатай төлөөлөгчид байна.
- Хороодын хуралд зайнаас санал өгөх процесс Төлөөлөгчдийн Танхимын хуралдаантай адил зарчмаар явагдах бөгөөд ялгаа нь гишүүний саналыг хорооны дарга эсхүл, хорооны цөөнхийг ахлагч тухайн гишүүний өмнөөс өгнө.
- Онц байдлын үед батлагдсан хууль тогтоомжийг хэлэлцэх болон хэрэгжүүлэх хугацааг ердийн үеэс богиносгосон байна. Өөрөөр хэлбэл, Төлөөлөгчдийн танхимаас гаргасан аливаа хууль тогтоомжийг түргэвчилсэн байдлаар хэлэлцэн

<sup>6</sup>Regular Session 2019-2020 House Resolution 834

<https://www.legis.state.pa.us/cfdocs/billinfo/billinfo.cfm?sYear=2019&sInd=0&body=H&type=R&bn=834>



баталж хэрэгжүүлнэ. Тухайлбал, хууль тогтоомжийн төслийг олон нийтэд танилцуулснаас хойш 24 цагийн хугацаанд хүлээн авч шийдвэрлэнэ гэснийг 3 цаг, хэлэлцэх асуудлууд, хороодын тайланг Төлөөлөгчдөд 12 цагийн өмнө хүргэнэ гэснийг 3 цаг, батлахад бэлэн болсон хууль, тогтоомжийг олон нийтэд танилцуулснаас 6 цагийн дараа эцсийн санал хураалт явагдана гэснийг 3 цаг болгож багасгасан байна.

- Хуульд заасан зарим тохиолдолд хууль тогтоомжийг цахим шуудангаар илгээж болохгүй гэсэн хязгаарлалт нь COVID-19 холбоотой асуудалд хамаарахгүй байхаар заажээ.
- Энэ түр журам нь Төлөөлөгчдийн танхим хүчингүй болгох хүртэл эсхүл, онц байдал цуцлагдах хүртэл хүчинтэй байна.

## 2.4. ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ ГЕРМАН УЛС

Германы Бундестаг (үгчилбэл, “Холбооны Их хурал”) болон Бундэсрат (үгчилбэл, “Холбооны Зөвлөл”) одоогоор хэвийн ажиллаж байна. Энэ 7 хоногт хуралдаж, корона хямралын эсрэг Онцгой байдал, хамгаалалтын талаар багц хуулийг “хурдавчилсан” горимоор баталж, ирэх долоо хоногоос эхлэн Улаан өндөгний баярыг тохиолдуулан 3 долоо хоног завсарлаж амарна.

Нэгдсэн фракц 2020 оны 03-р сарын 24-нд төлөвлөөд байсан хурлаа хийхгүй аж. Харин SPD фракц гишүүдээ сайн дураар ирж хуралдаа оролцохыг зөвшөөрсөн аж. Бундестагийн 2020 оны 03-р сарын 25-нд төлөвлөгдөөд буй чуулганы ажиллагаа онцгой (тусгай) журмаар явагдана.[1]

Төсвийн алдагдал үүсэхээс сэргийлэхийн тулд хямралын эсрэг авах багц арга хэмжээг санхүүжүүлэх зорилгоор төсвийн зарлагыг нэмэгдүүлэх тухай хуулийн төслийг “үнэмлэхүй” буюу Бундестагийн нийт гишүүдийн олонхоор (доод тал нь 355 депутат байх) батлах шаардлагатай тул SPD фракцийн тэргүүн бүх гишүүдийг 25-ны өдөр Берлинд хүрэлцэн ирж, Чуулганы нэгдсэн хуралдаанд оролцохыг уриалсан аж.[1]

Нэгдсэн фракц 2020 оны 03-р сарын 23-нд төлөвлөөд байгаа фракцийн хурлаа “фракцийн гишүүдийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх” үүднээс тэргүүлэх депутатууд, Засгийн газрын төлөөлөгчдийг хамруулан зайн хурал (теле-конференц) зохион байгуулахаар шийдвэрлэв. Иймээс фракцийн гишүүд санал хүсэлт, асуултаа холбогдох ажлын хэсгийн ахлагчид урьдчилж өгсөн байх шаардлагатай.[1]

SPD фракцийн тэргүүний мэдэгдсэнээр, фракцийн хурал ч тэр чуулганы хуралдааны танхимд депутатуудын хоорондын зайг аюулгүй хэмжээнд байлгах шаардлагатай. Мөн нийтийн тээвэр хэрэглэхийг хүсэхгүй байгаа депутат өөрийн авто машинтайгаа ирээд Бундестагийн далд гараашийн зогсоолд тавих боломжтой.[1]

Мөн түүний мэдэгдсэнээр, төсвийн алдагдлыг зогсоох тухай хуулийн шийдвэрийн талаарх үнэмлэхүй олонхийн санал хураалтад нэрийн дагуу зөвхөн өөрийн биеэр оролцох (сүүлийн чуулганы хуралдааныг чуулганы танхимаас гадуур хийсэн) тул цагийг сунгаж, депутат хоорондын зайг барих шаардлагатай.[1] (Чуулганы танхимд хуруугаа уншуулж ирцээ бүртгүүлээд гарч, хуралдаанаа өөр танхимд хийгээд,

ээлж дараатай буцаж чуулганы танхимд ирж хуруугаа уншуулан саналаа өгөх боломжтой [ГА])

Онцгой байдалтай холбоотой багц хуулийг холбогдох байнгын хороод хэлэлцэнэ. Ингэхдээ “тэд урьдчилан тохиролцоод цөөн тоотойгоор хуралдах боломжтой” хэмээн SPD фракцийн тэргүүн мөн мэдэгдэв. 2020/03/27-ний өдөр Бундэсрат багц хуулийг эцэслэн батална.[1]

Бундестагийн шийдвэр өнөөг хүртэл “гишүүдийн талаас илүү хувь нь хуралдааны танхимд хүрэлцэн ирснээр хүчин төгөлдөр болно” хэмээн Бундестагийн Дүрэм (дотоод журам)-д тусгагдсан байдаг аж. Тэгвэл корона хямралын үед дор хаяхад дөрөвний нэг нь ирснээр Бундестагийн шийдвэр гарах төслийг одоогийн байдлаар AfD намаас бусад фракциуд зөвшилцөөд бүгд дэмжсэн байна. AfD одоогоор хариугаа өгөөгүй боловч тэдэнгүйгээр эцсийн шийдвэр гарах боломжтой байгаа аж. Энэ нь байнгын хорооны хуралдаанд ч мөн адил хамаарна. Ингэхдээ Дүрмийн 216 дугаар зүйлийн “а” хэсэгт “Тусгай зохицуулалт” гэсэн гарчигтайгаар нэмэлт оруулах аж. Энэхүү зохицуулалт нь хамгийн оройтлоо гэхэд 2020 оны 9-р сарын 30 хүртэл хүчинтэй байх юм. Зүүний фракцийн тэргүүний мэдэгдсэнээр, түүнээс өмнө ч цуцлах боломжтой аж.[2]

Германы Үндсэн хуульд зөвхөн дайн байлдааны үед Бундестаг (цуглаж) хуралдаж чадахгүйд хүрвэл түүний үүргийг Бундестаг (гуравны хоёр нь), Бундэсрат (гуравны нэг нь)-аас нэгдэж бүрдсэн 48 гишүүнтэй хамтарсан хороо буюу Онцгой парламент гүйцэтгэж болохоор тусгасан байдаг аж.[2] Зарим улс төрчид үүнтэй төстэй хямралын үеийн “Онцгой Бундестаг” байгуулах талаар Үндсэн хуульд нэмэлт оруулах санал гаргаж байгаа боловч Бундестагийн гүйцэтгэх захирал (манай Тамгын газрын Ерөнхий нарийн бичгийн даргатай адил [ГА]) нь ийм шийдвэрийг маш нухацтай судалсны үндсэн дээр яаралгүй гаргах нь зүйтэй гэсэн байр суурьтай байгаа аж.[3]

Тэгээд ч Үндсэн хуульд өөрчлөлт оруулахын тулд гуравны хоёрын санал хэрэгтэй. Корона хямралын үед олон депутат, нэн ялангуяа муж улсуудын төлөөлөгчдийг халдвараас сэргийлэн нэг дор цуглуулах боломж хүндрэлтэй харагдаж байна.[3]

## **2.5. ШИНЭ ЗЕЛАНД УЛС<sup>7</sup>**

Бизнесийн хороо нь Танхимын санал хураалтад оролцох хүмүүсийн тоог багасгах зорилгоор зарим үйл ажиллагааг (хорооны хуралдаан, асуулт асуух, санал өгөх) цахим хэлбэрээр явуулахыг дэмжиж журмын төсөл боловсруулсан байна.

Тус төсөлд зааснаар Танхимд парламентын гишүүд аль болох хоорондоо зайтай сууна. Нийтийн танхимууд зочдод үйлчлэхгүй. Парламентын болон хороодын хуралдаанд оролцох нийгмийн гишүүд, ажиглагчид, гэрч, нотолгоо баримтыг оруулахгүй. Тэд тухайн хорооны фэйсбоок, цахим хуудас болон теле хурлаар баримт нотолгоо гарган ирүүлж болно.

<sup>7</sup> [https://www.parliament.nz/en/pb/hansard-debates/rhr/combined/HansDeb\\_20200319\\_20200319\\_16](https://www.parliament.nz/en/pb/hansard-debates/rhr/combined/HansDeb_20200319_20200319_16)  
<https://www.stuff.co.nz/national/health/coronavirus/120402590/coronavirus-parliament-changing-rules-to-run-on-skeleton-numbers-if-needed>

Хорооны гишүүд хурлын үеэр нэг нь нэгнээсээ 2 метрийн зайтай сууна. Энэ нөхцөлийг хангахын тулд хорооны хуралд видео, цахим хэлбэрээр оролцохыг зөвшөөрнө. Үүнийг хуралд оролцсонд тооцно.

Парламентын танилцах аяллыг түр зогсоосон. Мөн танхимд санал өгөгчдийн тоог зохицуулах, хязгаарлах зорилгоор санал хураалтад цахимаар оролцохыг зөвшөөрсөн. Хурлын дарга зарим нэг хороодын хурлыг зохион байгуулах, үйл ажиллагаа явуулах, алсаас цахим хэлбэрээр зохион байгуулах зэрэг онцгой зохицуулалтыг санал болгох эрхтэй. Харин Парламент нь ажлаа хэрхэн алсаас явуулах, цахим хэлбэрээр шийдвэр гаргах вэ гэдгийг Бизнесийн хороо шийдвэрлэнэ. Спикер болон дэд спикер эзгүй тохиолдолд түүний туслах спикер орлох боломжтой байхаар тусгажээ.

## 2.6. БҮГД НАЙРАМДАХ ПОЛЬШ УЛС

2020 оны 3-р сарын 02-ны өдрөөс албан хаагчид зайнаас, цахимаар ажиллаж эхэлсэн байна. 2020 оны 3-р сарын 08-ны өдөр Хямралын тухай хууль (Crisis act) батлагдсан байна. Парламентын нэгдсэн хуралдаан болон хороодын хуралдаан хойшлогдсон бөгөөд парламентын ажлын албаны ихэнх ажилтнууд цахимаар гэрээсээ ажиллаж байна.

Парламентын доод танхим 2020 оны 3-р сарын 27-ны өдөр хуралдаж коронавирусний улмаас эдийн засагт учирч болох хохирлоос сэргийлэх тухай засгийн газраас өргөн барьсан яаралтай хуулийн төслийг хэлэлцэж шийдвэрлэх, Сенатаас санал болгосон төсвийн тодотгол болон онц байдал тогтоосон одоогийн нөхцөл байдалд парламент хэрхэн ажиллах талаар парламентын дэгийн тухай хуульд оруулах нэмэлт, өөрчлөлт зэрэг асуудлаар хуралдахаар зэхэж байна. Одоогийн мөрдөж буй ариун цэвэр, эрүүл ахуйн дүрмийг баримтлан хуралдааныг хэдийд, хэрхэн зохион байгуулах талаар эцсийн шийдвэрийг гаргана гэсэн байна.<sup>8</sup>

Кабинетын зарим гишүүд коронавирусний халдвар авсны улмаас Засгийн газар үйл ажиллагаагаа алсын зайнаас цахимаар (*teleconference*) явуулж байна.<sup>9</sup>

2020 оны 3-р сарын 24-ний<sup>10</sup> хэвлэлийн бага хурал дээр Сеймын маршалл (Парламентын доод танхимын спикер) хатагтай Эльжбета Витек Сеймын Тэргүүлэгчдийн гаргасан шийдвэрийг танилцуулав. Сейм Танхимын хуралдааны дэгд өөрчлөлт оруулах саналыг дэмжсэн бөгөөд ийнхүү танхимд байх гишүүдийн тоог хязгаарласан байна. Хуралдаанд намын бүлгийн төлөөлөгч нар оролцох ба бусад гишүүд алсын зайнаас оролцох юм. Мөн тэрээр хурлын онцгой нөхцөл байдал зөвхөн эпидеми, эпидемийн аюул, түүнчлэн Үндсэн хуульд тусгагдсан онц байдал, байлдааны байдал, байгалийн гамшиг зэрэг гурван нөхцөл байдалд хамаарна гэдгийг онцоллоо. Тэргүүлэгчдийн 5 гишүүн уг саналыг дэмжиж, 1 гишүүн түдгэлзсэн бол дэмжээгүй санал гараагүй байна.

Шинэ горимоор ажиллах асуудлаар гишүүдэд IT-ийн мэргэжилтнүүд болон хуульчид заавар, зөвлөгөө өгч, богино хэмжээний видео зааварчилгаа өгөх юм.

<sup>8</sup> <https://polandin.com/47227651/parliament-mobilising-for-a-sitting-on-friday>

<sup>9</sup> <https://polandin.com/47189504/empty-corridors-of-power-coronavirus-affects-parliament-and-government>

<sup>10</sup> <http://www.sejm.gov.pl/Sejm9.nsf/komunikat.xsp?documentId=7743E94797CE0333C125853500520DB8>

Системийн ерөнхий туршилтыг 2020 оны 3-р сарын 26-нд явуулна. Шинэ горимоор Парламент 2020 оны 3-р сарын 27-нд хуралдана. Парламентын IT төвөөс гишүүдэд тусгай холбоос явуулж тухайн гишүүнийг мөн болохыг баталгаажуулахаас гадна гишүүний бүртгэлтэй гар утасны дугаараас SMS-ээр тухайн гишүүн мөн болохыг нотолж, оролцоог нь бүртгэх юм. Танхимд байрлах хоёр том дэлгэцээр гишүүдийг харж, сонсож болох юм.

## **2.7. ЛЮКСЕМБУРГИЙН ИХ ГҮНТ УЛС**

Парламент 2020 оны 3-р сарын 18-ны өдрийн нэгдсэн хуралдаанаараа Люксембургийн Засгийн газраас коронавирүсний тархалтын эсрэг авч хэрэгжүүлэх арга хэмжээ, хуулийн төслийг хэлэлцэн баталсан. Энэ асуудлыг хэлэлцсэн хуралдааны эхэнд хурлын дарга Фернанд Этгэн “Хямралын үед Депутатуудын танхим үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлнэ. Ялангуяа хямралын энэ цаг мөчид эрх зүйт төрийн зарчмуудыг төдийгүй парламентын хяналтын үүргийг бүрэн хангах нь урьд хэзээд байгаагүйгээс ч их чухал” гэж онцгойлон мэдэгдсэн. Парламентын Тамгын газрын ажилтнууд нийтээрээ гэрээсээ ажлаа гүйцэтгэж байна. Парламентын Байнгын хороодын хуралдааныг видео хэлбэрээр зохион байгуулж байна.

## **2.8. ХОЛБООНЫ БҮГД НАЙРАМДАХ БРАЗИЛ УЛС**

Бразилийн Парламент холбогдох хууль тогтоомжийг баталж нэгдсэн хуралдааныг виртуал хэлбэрээр явуулж эхэлсэн. Сенат анхны виртуал хэлбэрийн хуралдаанаа том хэмжээний видео хурал хийх зохих техник хэрэгсэл болон Zoom ашиглан явуулжээ. Сенатын гишүүдийн бүртгэлийн нууцлал болон санал хураалтын баталгааг хангах үүднээс хууль тогтоох зохион байгуулалтын тогтолцоогоо /legislative management system/ сайжруулсан.

Хуралдааныг виртуал хэлбэрээр явуулах ажлын хүрээнд дараах арга хэмжээг авсан байна.

### Сенат:

- Чуулганы хуралдааныг алсын зайнаас явуулах тухай хууль баталсан.
- Сенат нь алсын зайнаас санал өгөх боломжтой сайжруулсан Infoleg программыг ашиглан парламентын түүхэнд анх удаа алсын зайны хурал зохион байгуулсан байна.
- Office365, Zoom зэрэг программыг ашиглаж байна.

### Депутатуудын танхим:

- Infoleg программын шинэ хувилбар нь парламентын гишүүдийн ирц болон саналын бүртгэлийг хийх функцтэй бөгөөд энэхүү программ нь хууль батлах хүртлэх бүхий л үйл явцыг өөрөөр хэлбэл, хуулийн төслийн хувилбарууд, нэмэлт өөрчлөлт, санал асуулга бүрийн дүн, илтгэлүүд, хороодын хуралдааны хуваарь, хэлэлцэх асуудлууд болон бусад шаардлагатай мэдээллүүдийг хадгалах боломжтой.

- Менежментийн систем нь Infoleg системийг ашиглаж бүртгэсэн парламентын гишүүдийн ирц болон санал хураалтыг Хуулийн системтэй нэгтгэх үүрэгтэй. Энэ нь Ерөнхий нарийн бичгийн дарга болон Депутатуудын танхимын ерөнхийлөгчийн ашигладаг хяналтын функцыг өөртөө агуулдаг.
- Одоогоор парламент нь Zoom цахим платформыг ашиглаж 512 алсын зайнаас оролцогч, Депутатуудын танхим, Ерөнхий нарийн бичгийн дарга болон чуулганы цөөн тооны албан хаагчдыг холбон хурлаа зохион байгуулж байна. Нэг гишүүн нь хурлыг даргалж бусад оролцогчдын микрофоныг хянана. Чуулганы камеруудыг санал болгоны дүнг бусдад тодорхой харуулахаар байршуулсан ба Zoom-ийн авч буй дүрсийг том дэлгэцэн дээр харуулахаар зохион байгуулсан байна. Чуулган дээрх камераар авсан дүрс бичлэг болон Zoom-ээр авсан дүрсийг телевиз, youtube гэх мэт цахим портал руу шууд дамжуулах боломжтой.

(БРАЗИЛИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ТАНХИМЫН ТОГТООЛ-ын албан бус орчуулгыг хавсаргав.  
Хавсралт 1-ээс БРАЗИЛИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ТАНХИМЫН ТОГТООЛ-ыг үзнэ үү)

## 2.9. ИСПАНИЙН ХААНТ УЛС

Парламент хуралдааныг зайнаас явуулахтай холбоотой шинэ хуулиа яаралтай баталсан бөгөөд нэгдсэн хуралдааныг виртуал хэлбэрээр явуулж эхэлсэн. Испанид эрүүл мэндийн шалтгаанаар хуралдаанд сууж чадахгүй байгаа гишүүний саналыг зайнаас авах боломж бүхий технологийг хэрэглэж эхэлсэн байна. Хуралдааныг цахимаар явуулж зайнаас санал хураах хүрээнд дараах ажлууд хийгдэж байна.

- Конгрессын танхимын хувьд цөөн тооны ажилтнуудаас /зайлшгүй ажлын байрандаа ажиллах/ бусад бүх ажилтан teleworking хэлбэрээр ажиллаж байна.
- Хороодын хуралдаанд (Даргын зөвлөл гэх мэт) видео системийг ашиглаж байна.
- Ноцтой өвчтэй, эсхүл жирэмсэн гишүүд алсын зайнаас саналаа өгөх аппликейшнийг нэвтрүүлсэн бөгөөд Танхимын журамд Хэрэг эрхлэх газрын шийдвэрээр нэмэлт, өөрчлөлт оруулсан. Уг аппликейшнийг ашиглахад Цахим гарын үсгийн тухай хуулийн дагуу парламентын гишүүний техник төхөөрөмжид (PC, iPad, iPhone гэх мэт) цахим сертификат суулгасан байна.
- Аппликейшнаар санал өгөхдөө гишүүд Хэрэг эрхлэх газраар дамжуулан санал өгнө.

Эдгээр орнуудаас гадна Өмнөд Африкт парламентын хуралдааныг Zoom болон Microsoft Teams программ, Бахрейнд парламентын Дээд танхимын Хороодын хуралдааныг MSTEams программ ашиглан зайнаас явуулж байна (*Жич: Microsoft Teams бол байнгын ажлын байран дахь чат, видео уулзалт, файл хадгалах болон програмын интеграцийг нэгтгэсэн харилцаа холбоо, хамтын ажиллагааны нэгдсэн платформ юм*<sup>11</sup>).

<sup>11</sup> [https://en.wikipedia.org/wiki/Microsoft\\_Teams](https://en.wikipedia.org/wiki/Microsoft_Teams)

Мөн Индонези, Албани зэрэг улсад парламентын байнгын хороод онлайн хэлбэрээр ажиллаж байна.

**Зарим улс орны парламент хуралдаанаа цахимаар явуулж гишүүдийн саналыг алсын зайнаас хураах асуудлыг хэлэлцэн судалж байна.** Тухайлбал, Замби улс Өмнөд Африкийн тусламжтайгаар Zoom-ийг түршиж үзэхээр төлөвлөж байна.

Итали улс нь парламентын хуралдааныг видео хэлбэрээр хийх техник хэрэгслийг судалж байгаа бөгөөд шугам сүлжээ болон техник хэрэгсэлд асуудал үүсэх тохиолдолд санал хураалтыг утсаар авах боломжийг мөн судалж байна.

Ливаны Парламентын дарга хуралдааныг онлайн хэлбэрээр явуулах талаар 2020 оны 3-р сарын 25-нд мэдэгдсэн бөгөөд бэлтгэл ажлыг Мэдээлэл, технологийн байнгын хорооноос хариуцан гүйцэтгэх юм байна.

**Украины Парламент** виртуал нэгдсэн хуралдаан болон гишүүдийн саналыг алсын зайнаас хураах асуудлыг хэлэлцэж байна<sup>12</sup>.

Дээд Радагийн гишүүдээс 2020 оны 3-р сарын 20-нд №3250 дугаар бүхий хуулийн төсөл өргөн мэдүүлсэн бөгөөд төслийг Дээд Радагийн дэг, гишүүдийн ёс зүй болон зохион байгуулалтын асуудал хариуцах хороонд шилжүүлсэн.

Хууль батлагдвал 60 хоногийн хугацаанд парламентын нэгдсэн болон хороодын хуралдааныг видеоконференци хэлбэрээр онлайн явуулах боломжтой болно.

Онлайн хурлаар зөвхөн коронавирусний дэгдэлтийг зогсоох, тусгаарлах болон үндэсний аюулгүй байдал, батлан хамгаалах, эдийн засгийн арга хэмжээ, хүний эрхийн асуудалд холбогдох зайлшгүй чухал хуулийн төсөл, бусад актын төслүүдийг хэлэлцэн шийдвэрлэх юм.

*Хуралдааныг видеоконференци хэлбэрээр явуулах процессыг тоймолбол:*

Дээд Радагийн дарга нэгдсэн хуралдааныг видеоконференци хэлбэрээр явуулах шийдвэрийг Ерөнхийлөгчийн эсхүл, нийт гишүүдийн (конституционный состав) 1/3-ээс доошгүйн саналаар шийднэ.

Тамгын газраас видеоконференци хэлбэрээр явагдах нэгдсэн хуралдааны товыг гишүүдэд 24 цагийн өмнөөс мэдээлэх бөгөөд норматив актууд болон дагалдах бичиг баримтыг электрон хэлбэрээр илгээнэ.

Дээд Радагийн видеоконференци хэлбэрээр явагдах хурал нь хурлын танхимд эсхүл, Зөвшилцлийн зөвлөлийн танхимд явагдах бөгөөд хуралдааны үеэр танхимд зөвхөн Дээд Радагийн дарга, дэд дарга нар, хуулийн төслийг санаачлагч, тусгай хорооны төлөөлөгч, санал тоолох хорооны ажилтан, фракц болон бүлгүүдээс нэг нэг төлөөлөл, Тамгын газрын ажилтнууд байна. Бусад гишүүд онлайн горимоор оролцоно.

Видеоконференци хэлбэрээр явагдах нэгдсэн хуралдааны ирц бүрдсэн тохиолдолд даргалагч хуралдааныг нээнэ.

<sup>12</sup> <https://www.pravda.com.ua/rus/news/2020/03/23/7244755/>

Санал хураах:

- Хуралдаан даргалагч фракц, бүлгийн гишүүдийг нэрсийн дарааллаар (хамгийн том фракцаас эхэлж) дуудах бөгөөд тухайн гишүүний зураг дэлгэцэнд харагдахаар нэр болон баталгаажуулах дугаараа хэлж саналаа өгнө. Санал өгөх хугацаа гишүүн бүрийн хувьд 15 сек үргэлжилнэ. Шаардлагатай тохиолдолд хуралдаан даргалагч энэ хугацааг сунгаж болно.
- Санал өгөх болгонд санал тоолох хорооны ажилтан тухайн гишүүний саналыг бүртгэж авсан талаар мэдээллэнэ.
- Санал хураалтын дараа хуралдаан даргалагч Дээд Радагийн гаргасан шийдвэрийн талаар мэдэгдэнэ.
- Парламентын дарга батлагдсан хуульд даруй гарын үсгээ зурж, Ерөнхийлөгчид хүргүүлнэ.

Украины парламент энэхүү хуулийн төслийг батлахын тулд танхимаар цугларч санал хураах ёстой болоод байна.

**Эстони Улсын хувьд** Хороодын хуралдааныг *teleworking* хэлбэрээр явуулах боломж бүрдүүлэх тал дээр ажиллаж байна. 2020 оны 3-р сарын 16-ны өдөр Парламентын Үндсэн хуулийн хороо онцгой байдлын үед хороодын хуралдаануудыг цахимаар буюу алсын зайнаас зохион байгуулах асуудлыг хэлэлцсэн байна. Хорооноос Парламентын дэг, дотоод журмын тухай хуулийн дагуу Парламентын хороодын цахим буюу алсын зайнаас явуулах боломжтой гэж дүгнэсэн байна.

"Хуралдаанд оролцоход шаардлагатай нөхцөл болох үг хэлэх, асуулт асуух, санал өгөх зэргийг хангасан тохиолдолд хуралдааныг алсын зайнаас явуулж болно гэж одоогийн хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжийг тайлбарлаж болохоор байна" гэж Үндсэн хуулийн хорооны дарга мэдэгдсэн. Мөн онцгой нөхцөл байдлыг харгалзан хороодын үйл ажиллагааг тасалдуулахгүй, алсын зайнаас үргэлжлүүлэн ажиллах нь чухал болохыг онцолсон. Одоогийн байдлаар Парламентын дэгийг өөрчлөхийг яаравчлахгүй, харин онцгой байдал дуусахад холбогдох асуудлыг судлан, шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулж, хууль эрх зүйн орчныг илүү тодорхой болгоно гэж мэдэгдсэн.

Үндсэн хуулийн хорооноос Парламент дахь бүлгүүдэд захидал илгээж, Парламентын дэг, дотоод журмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай эсэхийг үнэлэхийг хүссэн байна. Хорооноос ирц, оролцооны асуудлыг эргэн харж, хууль эрх зүйн орчныг тодорхой болгохын тулд хорооны хуралдаанд алсын зайн оролцоог ямар нөхцөлд хангуулах вэ гэдгийг тодорхой болгох ёстой гэж холбогдох Хорооны дарга тус тус мэдэгдсэн байна.<sup>13</sup>

<sup>13</sup><https://www.riigikogu.ee/en/press-releases/constitutional-committee-en/constitutional-committee-rules-procedure-allow-holding-committee-sittings-teleworking-format/>

### **3. ПАРЛАМЕНТЫН БОЛОН БАЙНГЫН ХОРООДЫН ХУРАЛДААНЫГ ЕРДИЙН ГОРИМООР ЯВУУЛЖ БАЙГАА ЗАРИМ ОРНЫ ХЭРЭГЖҮҮЛЖ БҮЙ ТУРШЛАГА**

Хуралдааныг цахимаар явуулж зайнаас санал хураахад хууль болон дэг зөрчигдөх асуудал байгааг зарим улс орны парламент онцолж байна.

#### **3.1 БЕЛЬГИЙН ХААНТ УЛС<sup>14</sup>.**

Бельгийн Үндсэн хуулийн 53.3 дугаарт “Холбооны парламентын Сенат болон Төлөөлөгчдийн танхимын нийт гишүүдийн талаас илүү нь чуулганы хуралдаанд биечлэн оролцсоноор хуралдааныг хүчин төгөлдөр гэж үзнэ” хэмээн заасан тул парламентын нэгдсэн болон байнгын хороодын хуралдаан цахимаар хуралдаж байсан тохиолдол үгүй аж. Өнөөдрийг хүртэл Бельгийн Төлөөлөгчдийн танхимын нэгдсэн хуралдаан чуулганы дэгийн дагуу сонгодог хэлбэрээрээ хуралдаж байна.

Харин Төлөөлөгчдийн танхимын нэр бүхий 10 гишүүн Чуулганы хуралдааны дэгт өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2020 оны 3-р сард санаачлан хэлэлцүүлэхээр өргөн барьсан байна. Энэ өөрчлөлтийн гол санаа нь шинэ коронавирусын тархалттай холбогдуулан парламентын гишүүн чуулганд биеэр оролцох боломжгүй болсон тохиолдолд энэ тухайгаа хурлын даргад урьдчилан албан ёсоор мэдэгдэж, чуулганы хуралдааны үеэр явагдах санал хураалтад саналаа цахимаар өгөх эрхийг нээж өгч байгаа явдал юм. Дэгийн энэ өөрчлөлтийг 2020 оны 3-р сарын 26-ны нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж шийдэх аж.

Гэхдээ энэ нь парламентын чуулганы нэгдсэн болон Байнгын хороодын хуралдааныг цахимаар явуулна гэсэн үг биш бөгөөд зөвхөн эрүүл мэндийн шалтгаанаар биечлэн оролцох боломжгүй болсон тохиолдолд гишүүний санал өгөх эрхийг хангах юм.

#### **3.2 НИДЕРЛАНДЫН ХААНТ УЛС<sup>15</sup>**

Нидерландын парламент нэгдсэн хуралдаан болон байнгын хороодын хуралдааныг өмнө цахим хэлбэрээр явуулж байгаагүй. Коронавирусний тархалтыг зогсоох ажлын хүрээнд Нидерландын парламент шаардлагатай арга хэмжээг авч байгаа ч парламентын үйл ажиллагааны тасралтгүй зарчмыг ханган ажиллаж байна.

Гэхдээ хуралдааны тоог цөөлж, зөвхөн чухал шаардлагатай асуудлыг чуулганы нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж байгаа аж. Байнгын хороодын хуралдааныг биечлэн хийхийг түр зогсоож, бичгэн хэлбэрт шилжүүлсэн байна. Байнгын хороогоор хэлэлцэж байгаа асуудлаа бичгээр өгч, хариугаа бичгээр авч байна.

Түүнчлэн коронавирусын эсрэг хэрэгжүүлж буй Засгийн газрын ажлын мэдээллийг сонсохоос бусад асуудлаарх Засгийн газрын мэдээллийн цагийг хассан байна. Парламентын Тамгын газрын бүх ажилтан ажлаа гэрээсээ гүйцэтгэж байна. Парламентын үйл ажиллагаатай олон нийтийг танилцуулах ажлыг түр хугацаагаар мөн зогсоосон байна. Хэвлэл, мэдээллийнхэн болон олон нийт чуулганы үйл ажиллагааг [www.tweedekamer.nl](http://www.tweedekamer.nl). холбоосоор үзэж болно.

<sup>14</sup> МОНГОЛ УЛСААС БЕЛЬГИЙН ХААНТ УЛСАД СУУГАА ЭЛЧИН САЙДЫН ЯАМ-НЫ МЭДЭЭНЭЭС

<sup>15</sup> МОНГОЛ УЛСААС БЕЛЬГИЙН ХААНТ УЛСАД СУУГАА ЭЛЧИН САЙДЫН ЯАМ-НЫ МЭДЭЭНЭЭС



### **3.3 БҮГД НАЙРАМДАХ ФИНЛАНД<sup>16</sup>**

Парламент виртуал хэлбэрээр санал хураахыг хуулиар хориглосон байдаг тул ердийн горимоор ажиллаж байна.

Финландын Парламентын Даргын зөвлөлөөс 2020 оны 3-р сарын 19-нд коронавирусний тархалтын улмаас чуулганы нэгдсэн хуралдааныг явуулах шинэ удирдамжийг баталсан байна. Үүнд:

- Нэгдсэн чуулганы ирцийг чуулган эхлэхээс 15 минутын өмнө авч, гишүүд бөөнөөр чуулганы танхимд орж гарахыг хязгаарлах;
- Гишүүд өөрийн суудлаас үг хэлэх;
- Засгийн газрын гишүүдийн суудлын зохион байгуулалтыг өөрчилж, хоорондын зайг тэлэх;
- Намын бүлэг, зөвлөл нь хэлэлцүүлгийн явцад асуулт асуух гишүүдийг урьдчилан сонгосноор асуулт асуух үйл явцад нийт гишүүдийн ¼ оролцож, бусад гишүүд чуулганы танхимаас гадуур үзэх;
- Санал хураахаас бусад үед зөвхөн үг хэлэх саналтай гишүүд хуралдаанд оролцох зэрэг болно.

Түүнчлэн Парламентын Даргын зөвлөлөөс 2020 оны 3-р сарын 24-нд Онцгой байдлын тухай хуулийг үндэслэн коронавирусний тархалтын улмаас парламентын гишүүдийг цахимаар ажиллах эрхийг олгох нэмэлт удирдамжийг баталсан байна. Үүнд:

- Гишүүд нэгдсэн хуралдааны явцыг цахимаар үзэх;
- Хууль тогтоомжийн төслийг цахимаар өргөн барих;
- Урьдчилан мэдэгдсэн тохиолдолд цахимаар ажиллаж буй гишүүний ирцийг нэгдсэн хуралдаанд ирснээр тооцох;
- Санал хураалтыг цахимаар хийхгүй;
- Хороодын хурлыг зайлшгүй тохиолдолд хийх;
- Хороод хэлэлцэж буй асуудалтай холбоотой нэмэлт мэдээллийг цахимаар эсхүл, бичгээр авч байх зэрэг болно.

Одоогоор Парламентын чуулганыг цахим хэлбэрээр явуулах техник технологийн шийдэл, арга хэлбэр гаргаагүй байна.

### **3.4 БҮГД НАЙРАМДАХ АВСТРИ<sup>17</sup>**

Тус улсын үндсэн хууль болон Парламентын дэгийн тухай хуульд Үндэсний зөвлөлийн гишүүдийн дийлэнх олонх нь хүрэлцэн ирж, 2/3-оос дээш гишүүн санал өгснөөр хуралдааны шийдвэр хүчинтэйд тооцогдоно.

Үндэсний зөвлөл нь 2020 оны 3-р сарын 15-нд нэгдсэн хуралдаанаа хийж, коронавирусний тархалтыг зогсоох арга хэмжээний тухай холбооны хуулийг баталж, онц шаардлагатайгаас бусад тохиолдолд гэрээсээ гарахыг хориглож хөл хорио тогтоосон байна.

<sup>16</sup> Монгол Улсын Гадаад харилцааны яамны мэдээллээс

<sup>17</sup> Монгол Улсын Гадаад харилцааны яамны мэдээллээс

Хөл хорио нь Үндсэн хууль болон Парламентын хуралдааны дэгийн тухай хуульд, мөн парламентын гишүүдийн ирцийн тухай заалтуудад хамаарахгүй тул парламент үйл ажиллагаагаа үргэлжлүүлэн ажиллаж байна. Харин үүссэн нөхцөл байдалтай уялдуулан парламентын гишүүд, тамгын газрын ажилтнуудын аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээ авч байна. Үүнд:

- Байнгын хороо, нэгдсэн хуралдааны танхимын багтаамж зайг ихэсгэж (зочид хүлээн авах ёслолын өрөөг ашиглан) гишүүд өөр хоорондоо 1 м зайтай суух;
- Ажлын өрөөнөөс хуралдааныг видео хэлбэрээр үзэх;
- Хуралдаан үргэлжлэх хугацааг багасгах, хэлэлцүүлгийн үед асуулт тавихгүй байх;
- Нэн шаардлагатайгаас бусад тохиолдолд Тамгын газрын ажилтнууд гэрээсээ ажиллах зэрэг болно.

Хямралын үед хууль тогтоох байгууллагын үйл ажиллагааг доголдуулахгүй байхыг чухалчилж байгаа бөгөөд дэг өөрчлөх, цахимаар хуралдах санал одоогоор гараагүй байна.

### **3.5 ШВЕДИЙН ХААНТ УЛС<sup>18</sup>**

Тус улсын Парламентын тухай хуулийн дагуу парламентын болон хороодын хуралдаанд гишүүд биечлэн оролцох ёстой боловч энэ удаа парламентын дэгийн журамд өөрчлөлт оруулах замаар зарим зохицуулалтыг хийсэн байна.

Парламент дахь намын бүлгийн дарга нарын шийдвэрээр 2020 оны 3-р сарын 16-30-ны өдрүүдэд нийт 349 парламентын гишүүнээс зөвхөн 55 гишүүн нь хуралдаанд оролцох хязгаар тогтоосон. Үүнийг парламентын сонгуулийн дүнгээр авсан суудлын тоог харьцуулсан байдлаар тооцох бөгөөд намын бүлгүүд хуралдаанд оролцох гишүүдийг өөрсдөө сонгож байна.

Нөхцөл байдлаас шалтгаалан цаашид энэ байдлаар үргэлжлүүлэн ажиллах магадлалтай байна.

### **3.6 ДАНИЙН ХААНТ УЛС<sup>19</sup>**

Парламентын дэгийн хороо 2020 оны 3-р сарын 12-ны өдөр хуралдсан бөгөөд Засгийн газрын коронавирусний тархалтын эсрэг хэрэгжүүлж буй шийдвэрүүдийг харгалзан үзэж парламентын үйл ажиллагааг зогсоохгүй байх талаар шийдвэр гаргасан. Парламентын дарга “Парламент хууль тогтоомж батлах үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх нь нийгэмд маш чухал билээ. Иймд бид яаралтай асуудлыг парламентын хуралдаанаар хэлэлцэж батлах үүрэгтэй. Засгийн газар өнөөгийн хямралыг даван туулах бодлогыг хэрэгжүүлэх хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэхэд парламентын баталсан хууль тогтоомж нь чухал үүрэгтэй юм” гэж мэдэгджээ.

Парламент нь зөвхөн нэн чухал асуудлыг авч үзэх бөгөөд хууль тогтоомж батлах хэлэлцүүлгийн явцад холбогдох хороод хуралдах, харьяа сайд нар хороодын хуралд оролцох, мэдээллээр хангах үйл ажиллагаа хэвээр үргэлжилнэ. Бусад үйл

<sup>18</sup> Монгол Улсын Гадаад харилцааны яамны мэдээллээс

<sup>19</sup> Монгол Улсын Гадаад харилцааны яамны мэдээллээс

ажиллагааг Эрүүл мэндийн байгууллагын ерөнхий зааварчилгааны дагуу 2020 оны 4-р сарын 3-ны өдөр хүртэл түр зогсоохоор болсон.

Цахимаар хуралдах талаар ямар нэг шийдвэр гараагүй байна.

### **3.7 НОРВЕГИЙН ХААНТ УЛС<sup>20</sup>**

Парламент 2020 оны 3-р сарын 12-нд коронавирусний тархалтын улмаас парламентын нэгдсэн хуралдаан болон бусад арга хэмжээг дараах байдлаар явуулах шийдвэр гаргасан. Үүнд:

- Санал хураалт бүхий нэгдсэн хуралдаанд оролцох гишүүдийн тоог 87 байхаар хязгаарласан бөгөөд намын бүлгүүд оролцох гишүүдийг өөрсдөө сонгоно.
- 2020 оны 3, 4-р сард парламентын хуралдаан зохион байгуулах шаардлагатай эсэхийг парламентын дарга намын бүлгийн дарга нартай зөвшилцөж шийдвэрлэнэ.
- Хороодын хурлыг цөөн төлөөлөлтэй хийх, эсхүл технологийн дэвшлийг ашиглаж цахимаар хийх зэрэг болно.



<sup>20</sup> Монгол Улсын Гадаад харилцааны яамны мэдээллээс

## КОРОНАВИРУСНИЙ ХАЛДВАРЫН ДЭГДЭЛТИЙН ҮЕ ДЭХ ГАДААДЫН ЗАРИМ УЛСЫН ПАРЛАМЕНТЫН АЖИЛЛАГАА

/2020 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн байдлаар/

Улс	Нөхцөл байдал <sup>21</sup> /2020.04.01 12:00/	Парламентын үйл ажиллагаа	Тайлбар
1. Европын парламент <sup>22</sup>		Байршлыг шилжүүлсэн  Зайнаас хуралдаж байна.	ЕП-ын чуулганы нэгдсэн хуралдааныг 4 өдрөөс 1.5 өдөр (2020.03.30-04.02-ноос 2020.04.01-04.02) болгон богиносгож, “эрүүл мэндийн өндөр эрсдэлтэй” гэх үндэслэлээр Бельгийн нийслэл Брюсселиэс Францын Страсбург хотноо шилжүүлсэн. 2020.03.16-наас эхлэх 7 хоногт товлосон Хороодын хуралдааныг хойшлуулах шийдвэр гаргасан. <sup>23</sup> 2020.03.11-ний байдлаар ЕП-ын дийлэнх ажилтнууд зайнаас буюу teleworking ажлын горимд шилжээд байна. Одоогоор 7 хоногийн 70 хувьд нь зайнаас ажиллаж, 1.5 өдөр ажил дээрээ ажиллах бол цаашид нөхцөл байдлаас хамааран 100 хувьд хүргэх юм. <sup>24</sup> Гаднаас хүн оролцох арга хэмжээнүүдийг цуцалсан. 2020.03.26-нд Covid-19 өвчний улмаас гишүүн орнуудад туслах яаралтай арга хэмжээний талаар цахимаар <sup>25</sup> (видео хурал) явагдах ээлжит бус чуулганы санал

<sup>21</sup> <https://www.worldometers.info/coronavirus/> 2020.04.01-ний 12 цагийн байдлаар

<sup>22</sup> <https://www.euractiv.com/section/health-consumers/news/parliament-president-under-pressure-to-suspend-plenary/>

<sup>23</sup> <https://www.europarl.europa.eu/news/en/press-room/20200310IPR74511/ep-calendar-revised-to-ensure-parliament-can-exercise-its-core-functions>

<sup>24</sup> <https://techcrunch.com/2020/03/11/european-parliament-moves-to-majority-teleworking-in-response-to-covid-19/>

<sup>25</sup> [https://multimedia.europarl.europa.eu/en/plenary-session\\_20200326-0900-PLenary\\_vd](https://multimedia.europarl.europa.eu/en/plenary-session_20200326-0900-PLenary_vd)

			хураалтыг цахимаар явуулахаар болсон. 2020.07.31 хүртэл санал хураалтыг цахимаар явуулахаар шийдвэрлэсэн. <sup>26</sup> Хороодын хуралдааныг тодорхойгүй хугацаагаар хойшлуулсан хэвээр байна. <sup>27</sup>
<b>2. БНХАУ<sup>28</sup></b>	Бүртгэгдсэн-81518 Нас барсан - 3305	Хойшлуулсан	2020.02.24-нд БХАТИХ-ын 3 дугаар хуралдааныг хойшлуулах шийдвэрийг БХАТИХ-ын Байнгын хорооноос гаргасан. 2020.03.24-ний байдлаар хуралдаан хойшлогдсон хэвээр байна. <sup>29</sup>
<b>3. Иран</b>	Бүртгэгдсэн - 44605 Нас барсан - 2898	Түр зогсоосон	Парламентын 2 танхимын хороодын үйл ажиллагааг Коронавирусний тархалттай холбоотой Ассамблейн дарга болон Сенатын тэргүүний шийдвэрээр цуцалжээ. Царт тахлын улмаас парламентын үйл ажиллагаа түр завсарлаж, парламентын гишүүд гадаадад болон дотоодод явахгүй хэсэг хугацаанд “амрах”-д хүрээд байна. Үндэсний ассамблей 2020.03.12 ажлын өдөр хуралдахаар төлөвлөсөн боловч 5 ажлын өдөр хуралдаад түр хугацаагаар завсарласан. 2020.03.16-27-ны хооронд товлогдсон Төрийн ордон дахь байгууллагуудын болон Үндэсний ассамблейн дэд панелүүдийн 24 хуралдаан цуцлагдсан. Мөн хугацаанд товлогдсон Сенатын хороодын 18 хуралдааныг цуцалжээ.

<sup>26</sup> <https://techcrunch.com/2020/03/23/eu-parliament-moves-to-email-voting-during-covid-19/>

<sup>27</sup> <https://www.europarl.europa.eu/committees/en/home>

<sup>28</sup> <http://www.npc.gov.cn/englishnpc/c2763/202002/3be9ebfa9cbf4fe9b087a947951ce0e1.shtml>

<sup>29</sup> <http://www.npc.gov.cn/englishnpc/c2763/202002/3be9ebfa9cbf4fe9b087a947951ce0e1.shtml>

			<p>Парламентын 24 гишүүн буюу 10 орчим хувь нь вирусний шинжилгээнд эерэг гэсэн хариу авч, 2 гишүүн нас баржээ. Засгийн газрын албан тушаалтнуудад аялахыг хориглосон бөгөөд парламент тодорхойгүй хугацаагаар үйл ажиллагаагаа зогсоогоод байна.</p>
4. Испани <sup>30</sup>	<p>Бүртгэгдсэн - 95923 Нас барсан - 3305</p>	<p>Зайнаас хуралдаж байна.</p>	<p>2020.03.10-ны өдөр Парламентын доод танхимын үйл ажиллагааг 15 хоногоор түр зогсоох шийдвэр гаргасан. 2020.03.14-ны өдрөөс Улс орон даяар 15 хоногийн хугацаатай онц байдал зарласан. 2020.03.18-ны өдрийн парламентын хуралдаан дээр Ерөнхий сайд Педро Санчез улс орон даяар 15 хоногийн хугацаатай зарласан онц байдлыг нөхцөл байдал дордсоны улмаас 2020.04.11-ний өдөр хүртэл дахин сунгах шаардлагатай байгааг мэдэгдсэн байна. Парламентын танхимд болсон энэ хуралдаанд 28 гишүүн, 5 сайд оролцсон. Парламент хуралдааныг зайнаас явуулахтай холбоотой шинэ хуулиа яаралтай баталсан. Конгрессын танхимын хувьд цөөн тооны ажилтнуудаас /зайлшгүй ажлын байрандаа ажиллах/ бусад бүх ажилтан teleworking хэлбэрээр ажиллаж байна. Хороодын хуралдаанд (Даргын зөвлөл гэх мэт) видео системийг ашиглаж байна.</p>

<sup>30</sup> <https://www.theguardian.com/world/2020/mar/13/european-countries-take-radical-steps-to-combat-coronavirus>

			Ноцтой өвчтэй, эсхүл жирэмсэн гишүүд алсын зайнаас саналаа өгөх аппликейшнийг нэвтрүүлсэн.
<b>5. Франц</b>	Бүртгэгдсэн - 52128 Нас барсан - 3523	Хуралдааны тоог хязгаарласан.	<p>Францын Үндэсний ассамблейн 9 гишүүний коронавирусний шинжилгээ эерэг гарсан. Үүнтэй холбоотой парламентын доод танхимын үйл ажиллагааг 2020.03.22 хүртэл түр хугацаагаар зогсоосон байна.</p> <p>Засгийн газраас хурал, уулзалтыг аль болох бага хийх, ширээнүүдийг өдөрт 2 удаа ариутгаж арчих, хурал, уулзалтыг аль болох зайнаас зохион байгуулах /видео хурал/, чухал бус уулзалтыг цуцлах зэрэг арга хэмжээг хэрэгжүүлж байна.</p> <p>2020.03.16-наас бүх цэцэрлэг, сургууль, их дээд сургуулийн үйл ажиллагааг түр зогсоох шийдвэр гаргажээ.</p> <p>2020.03.22-нд Үндэсний ассамблейн Тусгай хороо цөөн тооны гишүүдтэйгээр хуралдан коронавирусний тархалттай тэмцэхэд Засгийн газарт тусгай эрх олгох хуулийг яаралтай батлав.</p> <p>2020.03.29-нд Үндэсний Ассамблей цөөн гишүүний бүрэлдэхүүнтэй дахин хуралдахаар шийдвэрлэсэн байна.</p> <p>Үндэсний ассемблей болон Засгийн газар нь үйл ажиллагаагаа хязгаарласан бөгөөд зөвхөн Коронавирустай холбоотой яаралтай, чухал ажлыг судлан хянаж шийдвэрлэх хэмжээнд ажиллахаар болсон. Хуралдааныг “нүүр нүүрээрээ харж” явуулах боловч аль болох</p>

			хамгийн бага тооны гишүүд, ажилтнуудыг оролцуулахаар болжээ.
<b>6. Канад</b> <sup>31</sup>	Бүртгэгдсэн - 8612 Нас барсан - 101	2020.04.20-ын өдрийг хүртэл түр зогсоосон (5 долоо хоног)	2020.03.13-ны өдөр Парламент дахь бүх намууд Нийтийн танхим болон Сенатын үйл ажиллагааг 5 долоо хоногоор (Нийтийн танхим 2020.04.20, Сенат 2020.04.21-ний өдрийг хүртэл) түр зогсоохоор санал гарган, шийдвэрлэсэн. Шаардлагатай тохиолдолд хугацааг сунгаж болно. Мөн 2020.03.30-нд Холбооны төсвийг хэлэлцэх байсныг хойшлуулсан. Шинэ тов одоогоор гараагүй байна.
<b>7. Эстони</b> <sup>32</sup>	Бүртгэгдсэн - 745 Нас барсан - 4	Хуралдааны тоог хязгаарласан	2020.03.12-нд 2020.05.01 хүртэл Онц байдал зарласан. 2020.03.13-нд Эстоний парламент зөвхөн цаг үеийн чухал асуудлыг шийдвэрлэхээр тогтсон. Мөн нэгдсэн хуралдааныг Даваа-Пүрэв гарагт явуулдаг байсныг зөвхөн Даваа гарагт, асуулгыг Лхагва гарагт явуулахаар тус тус шийдвэрлэсэн байна. Хороодын хуралдааныг Даваа гарагт зөвхөн шаардлагатай тохиолдолд явуулна. Ахмадын зөвлөлөөс Парламентын Үндсэн хуулийн хороонд онц нөхцөл байдалд Хороодын хуралдааныг алсын зайнаас явуулах талаар тогтоол боловсруулахыг үүрэг болгов.

<sup>31</sup> <https://www.cbc.ca/news/politics/parliament-suspended-1.5496469>

<sup>32</sup> <https://www.riigikogu.ee/en/press-releases/others/riigikogu-will-reorganise-work-prevent-spread-coronavirus/>



			<p>2020.03.16-нд Үндсэн хуулийн хороо хуралдаж Онцгой байдлын үед хорооны хурлыг цахимаар (teleworking) зохион байгуулах талаар ярилцаж, Рийгикогугийн тухай хууль болон Дотоод журмын тухай хуулиар хороодын хуралдаанд оролцох шаардлагатай бүх нөхцөл (тайлбар хийх, асуулт асуух, санал өгөх) хангагдаж байгаа тохиолдолд хуралдааныг цахим хэлбэрээр явуулах боломжтой гэж санал нэгдэв. Хорооны дарга онцгой нөхцөл байдлыг харгалзан хороодын хурал, ажил тасалдахгүй байх нь чухал бөгөөд цахим хэлбэрээр үргэлжилж болох талаар хэлэв. Мөн процедурын журмыг яаран өөрчлөх шаардлагагүй, дараа нь нөхцөл байдалд дүн шинжилгээ хийсний үндсэн дээр өөрчлөлт оруулж болох юм гэж хорооны байр суурийг илэрхийллээ.<sup>33</sup></p> <p>20.03.2020 Европын Холбооны асуудал эрхэлсэн хорооны дарга Аннели Отт Комиссын нэрийн өмнөөс Европын Комиссын Ерөнхийлөгч Урсула фон дер Лейенд захидал илгээж, Европын Комиссоос зохион байгуулалтад тэргүүлэх үүрэг гүйцэтгэхийг хүсч, энэ ажилд хамтран ажиллахаа мэдэгдсэн.</p> <p>2020.03.23-ны хуралдаанаар 2020.03.25-нд Рийгикогугийн Удирдах зөвлөлийн сонгуулийг хийхээр шийдвэрлэсэн.</p>
8. Пакистан <sup>34</sup>	Бүртгэгдсэн - 1938 Нас барсан - 26	2020.04.05 хүртэл түр зогсоосон	<p>Парламентын ээлжит чуулган 2020.03.19-ны өдөр хаах байсан ч корона вирусний халдварын дэгдэлттэй холбоотойгоор 2020.03.14-нд Үндэсний</p>

			<p>Ассамблейн үйл ажиллагааг болон дээд, доод танхимын байнгын хороодын хуралдааныг түр зогсоосон. Сенатын үйл ажиллагааг 2020.04.05 хүртэл түр зогсоосон байна.</p> <p>2020.03.25-нд Үндэсний Ассамблейн спикер Асад Кайзерын санаачилгаар Сенат ба Үндэсний Ассамблейн парламентын удирдагчдын хамтарсан уулзалт 2020.03.25-ны өдөр Парламентын ордонд болно. Энэхүү уулзалтаар коронавирусаас үүдэлтэй нөхцөл байдал ба түүний эдийн засагт үзүүлэх нөлөөллийг хэлэлцэж, коронавирусний эсрэг ажиллах парламентын хороог байгуулах асуудлыг хэлэлцэх юм.<sup>35</sup></p>
9. Филиппин <sup>36</sup>	Бүртгэгдсэн - 2084 Нас барсан - 88	2020.04.12 хүртэл түр зогсоосон	<p>2020.03.13-ны өдөр Парламентын доод танхимаас Танхимын үйл ажиллагааг 2020.03.16-04.12-ны өдрийг дуустал түр зогсоохоор шийдвэрлэсэн. Ажилтнуудыг зайнаас ажиллуулах бөгөөд холбогдох хэлтэс, хороодыг ээлжээр ажиллуулна. Парламентын комплекст зөвхөн COVID-19-ын халдвартай тэмцэх, үр нөлөөг бууруулах асуудлаарх холбогдох хорооны хурал, сонсгол, хэлэлцүүлгийг зохион байгуулна.</p> <p>2020.03.24-нд онцгой хуралдааныг зарлан хуралдуулж коронавирусний дэгдэлтийн</p>

<sup>33</sup> <https://www.riigikogu.ee/en/press-releases/constitutional-committee-en/constitutional-committee-rules-procedure-allow-holding-committee-sittings-teleworking-format/>

<sup>34</sup> <https://www.pakistantoday.com.pk/2020/03/14/first-pakistans-parliamentary-business-suspended-due-covid-19-scare/>

<sup>35</sup> [www.thenews.com.pk/print/633780-pm-not-to-attend-parliamentary-group-leaders-meeting-tomorrow](http://www.thenews.com.pk/print/633780-pm-not-to-attend-parliamentary-group-leaders-meeting-tomorrow)

<sup>36</sup> <https://news.abs-cbn.com/news/03/13/20/congress-house-of-representatives-batasan-suspends-work-march-16-to-april-12>

			эсрэг авах арга хэмжээтэй холбоотой онцгой эрхийг Ерөнхийлөгчид олгох хуулийн төслийг баталсан.
<b>10. Өмнөд Африк<sup>37</sup></b>	Бүртгэгдсэн - 1353 Нас барсан - 5	Зайнаас хуралдаж байна	2020.03.17-ноос эхлэн Парламентын үйл ажиллагааг түр зогсоох шийдвэрийг Парламентын тэргүүлэгч, парламент дахь намын бүлгийн дэг сахиулагч, намын бусад төлөөлөгч нарын шуурхай хурлаар шийдвэрлэсэн байна. Тус шийдвэрийг Засгийн газраас коронавирүсний халдварын тархалтыг зогсоох үүднээс 100-аас дээш хүн оролцох уулзалт, цуглааныг хориглосныг үндэслэн гаргажээ. Хуралдааныг зайнаас явуулахад Zoom болон Microsoft Teams (MSTeams) платформыг ашиглаж байна.
<b>11. Кени<sup>38</sup></b>	Бүртгэгдсэн - 59 Нас барсан - 1	2020.04.14 хүртэл түр зогсоосон	2020.03.17-04.14 хүртэл коронавирүсний халдварын тархалттай холбоотойгоор Парламентын дээд, доод танхимүүдын үйл ажиллагааг түр зогсоох шийдвэр гаргасан гэж Үндэсний Ассамблейн спикер мэдээлсэн.
<b>12. Итали</b>	Бүртгэгдсэн - 105792 Нас барсан - 12428	Хуралдааны тоог хязгаарласан.	Байнгын хороодын хуралдаанууд цуцлагдсан. Онц шуурхай асуудлаар Парламентын танхимууд видеоконференц явуулах бөгөөд санал хураалт (нэгдсэн хуралдаан)-ыг долоо хоногийн зөвхөн 1 өдөр буюу Лхагва гарагт явуулахаар шийдвэрлэсэн. Парламентын гишүүдийг танхимд нэвтрэхэд биеийн

<sup>37</sup> <https://www.timeslive.co.za/politics/2020-03-17-parliament-to-shut-down-until-further-notice-because-of-covid-19/>

<sup>38</sup> <https://www.pulselive.co.ke/news/parliament-suspends-sitting-over-coronavirus/9k5tmfd>

			халууныг хэмжин оруулж, гишүүд хоорондоо хамгийн багадаа 1 метрийн зайтай суух юм. Парламентын хуралдааныг видео хэлбэрээр хийх техник хэрэгслийг судалж байгаа бөгөөд шугам сүлжээ болон техник хэрэгсэлд асуудал үүсэх тохиолдолд санал хураалтыг утсаар авах боломжийг мөн судалж байна.
<b>13. Австрали</b>	Бүртгэгдсэн - 4804 Нас барсан - 20	2020.08 дугаар сар хүртэл зогсоосон <sup>39</sup> Хороодын үйл ажиллагаа алсын зайнаас явагдана	2020.03.16-наас эхлэн Парламентын ордонд нэвтрэх нөхцөлийг хязгаарлаж, Парламентын ордонд хийх томоохон арга хэмжээг хойшлуулж цуцалсан. 2020.03.23-наас эхлэх Хороодын сонсголд олон нийтийг оруулахгүй бөгөөд зөвхөн онц шаардлагатай тохиолдолд гэрчийг оролцуулах юм. Хороодод сонсгол зохион байгуулах тохиолдолд видео, телеконференцийн горимд шилжихийг зөвлөсөн. Хороодын үйл ажиллагааг Парламентын цахим хуудсаар дамжуулна.
<b>14. Непал<sup>40</sup></b>	Бүртгэгдсэн - 5	Тодорхойгүй хугацаагаар түр зогсоосон.	2020.03.13-03.20 хүртэл коронавирусын халдварын тархалттай холбоотойгоор Парламентын дээд, доод танхимуудын үйл ажиллагааг түр зогсоох шийдвэр гаргасан. 2020.03.20-нд Парламентын дээд танхимын хуралдааныг тодорхойгүй хугацаагаар дахин хойшлуулав. Мөн Засгийн газрын зааварчилгааг үндэслэн (нэг дор 25-аас дээш хүн цугларч

<sup>39</sup> <https://www.aph.gov.au>

<sup>40</sup> <https://myrepublica.nagariknetwork.com/news/parliament-put-off-for-eight-days-over-coronavirus-fears/>

			болохгүй) төлөөлөгчдийн танхимын үйл ажиллагааг дахин мэдэгдэл гаргах хүртэл түр зогсоосон. 2020.03.24-нөөс Засгийн газраас бүх орон даяар 7 хоногийн хугацаатай хөл хорио тогтоох шийдвэрийг гаргажээ.
<b>15. БНСУ</b>	Бүртгэгдсэн - 9887 Нас барсан - 165	Ердийн горимоор ажиллаж байна.	Парламентын сонгууль 2020.04.15-нд явагдана.
<b>16. Их Британи<sup>41</sup></b>	Бүртгэгдсэн - 25150 Нас барсан - 1789	Хуралдааны тоог хязгаарласан. Хороод алсын зайнаас хуралдаж байна. <sup>42</sup>	2020.03.16-наас эхлэн Парламентын ордонд нэвтрэх нөхцөлийг хязгаарлаж, Парламентад хүлээн авалт хийхийг зогсоосон. ДЭМБ-аас шинэ корона вирусний халдварыг цар тахлын хэмжээнд хүрсэн гэж дүгнэсэнтэй холбоотойгоор тодорхой улс, бүс нутагт аялахгүй байхыг зөвлөхийн сацуу Парламентын гишүүд, парламентын бүлгэм, хамтрагч байгууллагуудад парламентын айлчлал хийхгүй байх, төлөөлөгчид нь эрсдэлт бүлэгт хамарч буй эсэх асуудалд онцгой анхаарахыг хатуу зөвлөсөн байна. - Их Британий парламент нэгдсэн хуралдааныг цөөн тооны гишүүдтэй явуулж байна (Нийтийн танхимын ирц 40 байхаар).

<sup>41</sup> <https://www.parliament.uk/business/news/2020/march/uk-parliament-coronavirus-update/>

<sup>42</sup> Following a joint meeting today, the Commissions of the House of Lords and House of Commons have issued the following statement:

"The Commissions of both Houses met today to discuss Parliament's response to Coronavirus. There are no plans to suspend Parliament.

"We continue to act entirely in line with the advice of Public Health England and the Speakers and political leadership of both Houses are keeping the situation under constant review."

<https://www.telegraph.co.uk/global-health/science-and-disease/coronavirus-uk-latest-news-italy-covid-19-deaths-cases-update/>

			<p>- Нийтийн танхим нь хуралдааны дэгт нэмэлт, өөрчлөлт оруулснаар Хороодын хуралдаанд гишүүд алсын зайнаас оролцох боломж бүрдсэн.</p> <p>- Ажилтнуудыг аль болох алсын зайнаас ажиллуулахыг дэмжиж байгаа бөгөөд зайнаас ажиллах нөхцөл байдлыг судалж байна.</p>
<b>17. Нидерланд</b>	Бүртгэгдсэн - 12595 Нас барсан - 1039	Хуралдааны тоог хязгаарласан. Байнгын хороодын хуралдааныг бичгэн хэлбэрээр явуулж байна. <sup>43</sup>	<p>2020.03.31 хүртэл Парламентын ордонд зөвшөөрөл бүхий сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудаас бусад иргэдийг нэвтрүүлэхгүй. Хуралдаан, хэлэлцүүлгүүдийг цахим хуудаснаас үзэх боломжтой. Хуралдааны тоог цөөлж, зөвхөн чухал шаардлагатай асуудлыг нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж байна.</p> <p>Засгийн газрын зөвхөн коронавирусын эсрэг хэрэгжүүлж буй ажлын талаарх мэдээллийг сонсоно.</p> <p>Байнгын хороодын хуралдаанд биечлэн оролцохыг түр зогсоож, бичгэн хэлбэрт шилжүүлсэн.</p>
<b>18. Норвеги</b>	Бүртгэгдсэн - 4641 Нас барсан - 39	Хуралдааны тоог хязгаарласан. <sup>44</sup>	<p>2020.03.07-ноос Парламентын ордонтой танилцах арга хэмжээг зогсоосон.</p> <p>2020.03.16-ны өдрийн Парламентын хуралдаанаар коронавирусын халдвартай холбоотой шуурхай асуудлыг шийдвэрлэх тусгай хороо байгуулсан.</p> <p>2020.03.12-нд 2020 оны 4-р сарыг дуустал хэрэгжих түр тогтоол баталж, хуралдаанд оролцон</p>

<sup>43</sup> <https://www.houseofrepresentatives.nl/news/dutch-house-representatives-closed-public>

<sup>44</sup> <https://www.stortinget.no/en/In-English>

			<p>санал өгөх гишүүдийг тоог 87-оор тогтоосон. Үндсэн хуульд заасны дагуу нийт гишүүдийн талаас дээш хувь хүрэлцэн ирснээр хуралдааныг хүчинтэйд тооцох юм (нийт 169 гишүүнтэй).</p> <p>Дээрх хугацаанд гишүүд аль болох хоорондоо зайтай сууж, заавал өөрийн суудалдаа суух албагүй байна.</p> <p>Хороодын хуралдааныг цөөн тооны төлөөлөлтэй, эсхүл цахимаар хийнэ.</p> <p>2020.03.25 Парламентын гишүүдийн тэн хагас нь гэрээсээ ажлаа хийж байна. Үндсэн хуульд зааснаар санал хураалтад биечлэн оролцох шаардлагатай тул зайнаас санал хураах боломжгүй байна.</p>
<b>19. Япон</b>	Бүртгэгдсэн - 2229 Нас барсан - 66	Ердийн горимоор ажиллаж байна. <sup>45</sup>	Парламентын ордонтой танилцах арга хэмжээг 2020.03.01-31-ний өдөр хүртэл зогсоосон.
<b>20. Шинэ Зеланд</b>	Бүртгэгдсэн – 708 Нас барсан - 1	Хуралдааны тоог хязгаарласан. <sup>46</sup>	<p>2020.03.17-ноос эхлэн Парламентын ордонтой танилцах арга хэмжээг түр зогсоосон, ордонд байрлах кафед гаднаас хүн орохыг тодорхойгүй хугацаагаар хязгаарласан.</p> <p>Бизнесийн хороо нь Танхимын санал хураалтад оролцох хүмүүсийн тоог багасгах зорилгоор зарим үйл ажиллагааг (хорооны хуралдаан, асуулт асуух, санал өгөх) цахим хэлбэрээр явуулахыг дэмжиж журмын төсөл боловсруулсан байна.</p>

<sup>45</sup> [http://www.shugiin.go.jp/internet/index.nsf/html/index\\_e.htm](http://www.shugiin.go.jp/internet/index.nsf/html/index_e.htm)

<sup>46</sup> <https://www.parliament.nz/en/get-involved/features/update-on-public-access-to-new-zealand-parliament/>

			<p>- Нийтийн танхим нь хуралдааны дэгт нэмэлт, өөрчлөлт оруулснаар Хороодын хуралдаанд гишүүд алсын зайнаас оролцох боломж бүрдсэн.</p> <p>- Ажилтнуудыг аль болох алсын зайнаас ажиллуулахыг дэмжиж байгаа бөгөөд зайнаас ажиллах нөхцөл байдлыг судалж байна.</p>
<b>17. Нидерланд</b>	Бүртгэгдсэн - 12595 Нас барсан - 1039	Хуралдааны тоог хязгаарласан. Байнгын хороодын хуралдааныг бичгэн хэлбэрээр явуулж байна. <sup>43</sup>	<p>2020.03.31 хүртэл Парламентын ордонд зөвшөөрөл бүхий сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудаас бусад иргэдийг нэвтрүүлэхгүй. Хуралдаан, хэлэлцүүлгүүдийг цахим хуудаснаас үзэх боломжтой. Хуралдааны тоог цөөлж, зөвхөн чухал шаардлагатай асуудлыг нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэж байна.</p> <p>Засгийн газрын зөвхөн коронавирусын эсрэг хэрэгжүүлж буй ажлын талаарх мэдээллийг сонсоно.</p> <p>Байнгын хороодын хуралдаанд биечлэн оролцохыг түр зогсоож, бичгэн хэлбэрт шилжүүлсэн.</p>
<b>18. Норвеги</b>	Бүртгэгдсэн - 4641 Нас барсан - 39	Хуралдааны тоог хязгаарласан. <sup>44</sup>	<p>2020.03.07-ноос Парламентын ордонтой танилцах арга хэмжээг зогсоосон.</p> <p>2020.03.16-ны өдрийн Парламентын хуралдаанаар коронавирусын халдвартай холбоотой шуурхай асуудлыг шийдвэрлэх тусгай хороо байгуулсан.</p> <p>2020.03.12-нд 2020 оны 4-р сарыг дуустал хэрэгжих түр тогтоол баталж, хуралдаанд оролцон</p>

<sup>43</sup> <https://www.houseofrepresentatives.nl/news/dutch-house-representatives-closed-public>

<sup>44</sup> <https://www.stortinget.no/en/In-English>



			2020.03.25 Парламент дөрвөн 7 хоногийн хугацаанд улс орон даяар хөл хорио тогтоосон. Засгийн газрын үйл ажиллагааг аль болох багасгаж хязгаарлах үүднээс Засгийн газар болон парламентын сөрөг хүчний гишүүдээс бүрдсэн тусгай хороо байгуулан ажиллаж байна <sup>47</sup> .
<b>21. Бельги</b>	Бүртгэгдсэн - 12775 Нас барсан - 705	Ердийн горимоор хуралдаж байна.	Төлөөлөгчдийн танхимын нэгдсэн хуралдаан дэгийн дагуу сонгодог хэлбэрээрээ хуралдаж байна. Гишүүдийн зүгээс хуралдааны дэгд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг өргөн барьсан бөгөөд 2020.03.26-ны нэгдсэн хуралдаанаар хэлэлцэж шийдэх аж. Энэ өөрчлөлт батлагдвал зөвхөн эрүүл мэндийн шалтгаанаар биечлэн оролцох боломжгүй болсон тохиолдолд гишүүний санал өгөх эрхийг хангах юм.
<b>22. Люксембург</b>	Бүртгэгдсэн - 2178 Нас барсан - 23	Байнгын хороод зайнаас хуралдаж байна.	Парламентын Тамгын газрын ажилтнууд нийтээрээ гэрээсээ ажлаа гүйцэтгэж байгаа бөгөөд Байнгын хороодын хуралдааныг видео хэлбэрээр зохион байгуулж байна.
<b>23. Бахрейн</b>	Бүртгэгдсэн - 567 Нас барсан - 4	Хороод зайнаас хуралдаж байна.	Shura зөвлөл буюу парламентын Дээд танхим нь MSTeams программыг ашиглан Хороодыг алсын зайнаас ажиллах боломжоор хангасан байна.
<b>24. Ботсван</b>	Бүртгэгдсэн – 4 Нас барсан - 1	Түр зогсоосон	Парламент түр завсарласан байгаа бөгөөд үргэлжлүүлэн завсарлана гэсэн шийдвэртэй байна.
<b>Бразил</b> 25.	Бүртгэгдсэн - 5812 Нас барсан - 202	Зайнаас хуралдаж байна.	<u>Сенат</u> : Чуулганы хуралдааныг алсын зайнаас явуулах тухай хууль баталсан. Нэгдсэн

<sup>47</sup> <https://www.ipu.org/parliaments-in-time-pandemic>


			<p>хуралдааныг виртуал хэлбэрээр явуулж эхэлсэн бөгөөд Сенат анхны виртуал хэлбэрийн хуралдаанаа том хэмжээний видео хурал хийх зохих техник хэрэгсэл болон Zoom ашиглан явуулжээ.</p> <p><u>Депутатуудын танхим:</u> Zoom цахим платформыг ашиглаж 512 алсын зайнаас оролцогч, Депутатуудын танхим, Ерөнхий нарийн бичгийн дарга болон чуулганы цөөн тооны албан хаагчдыг холбон хурлаа зохион байгуулж байна.</p>
26. Финланд	<p>Бүртгэгдсэн - 1418 Нас барсан - 17</p>	<p>Хуралдааны тоог хязгаарласан.</p>	<p>Парламент виртуал хэлбэрээр санал хураахыг хуулиар хориглосон байдаг тул ердийн горимоор ажиллаж байна.</p> <p>2020.03.19-нд Парламентын Даргын зөвлөлөөс коронавирүсний тархалтын улмаас чуулганы нэгдсэн хуралдааныг явуулах шинэ удирдамжийг баталсан байна.</p> <p>2020.03.24-нд Парламентын Даргын зөвлөлөөс Онцгой байдлын тухай хуулийг үндэслэн коронавирүсын тархалтын улмаас парламентын гишүүдийг цахимаар ажиллах эрхийг олгох нэмэлт удирдамжийг баталсан байна.</p>
27. Герман	<p>Бүртгэгдсэн - 71808 Нас барсан - 775</p>	<p>Хуралдааны тоог хязгаарласан.</p>	<p>Хуралдаан товч хөтөлбөртэй, зөвхөн шаардлагатай гишүүд оролцоно. Танхимын үйл ажиллагааг эрэмбэлж зөвхөн зайлшгүй чухал хэлэлцүүлгийг</p>

			явуулна. Бундестагийн хуралдааныг багасгасан тооны гишүүнтэй явуулахад ирцийн асуудлыг хэрхэн шийдвэрлэх талаар хэлэлцүүлэг үргэлжилж байна.
28. Тунис	Бүртгэгдсэн - 394 Нас барсан - 10		Одоогоор ямар нэг арга хэмжээ аваагүй боловч парламентыг түдгэлзүүлж, эрх мэдлийг гүйцэтгэх засаглалд шилжүүлэх санал дэвшүүлсэн. Үүнийг хэрхэн зохицуулах процесс одоогоор тодорхойгүй байна.
29. Замби	Бүртгэгдсэн - 36		Өмнөд Африкийн тусламжтайгаар Zoom-ийг туршиж үзэхээр төлөвлөж байна.
30. Украин	Бүртгэгдсэн – 645 Нас барсан - 17	Ердийн горимоор хуралдаж байна.	Виртуал нэгдсэн хуралдаан болон гишүүдийн саналыг алсын зайнаас хураах асуудлыг хэлэлцэж байна. 2020.03.20-нд Дээд Радагийн гишүүдээс хуулийн төсөл өргөн барьсан бөгөөд хууль хүчин төгөлдөр болмогц 60 хоногийн хугацаанд парламентын нэгдсэн болон хороодын хуралдааныг видеоконференци хэлбэрээр явуулах боломжтой болно.
31. Америк	Бүртгэгдсэн - 188578 Нас барсан - 3890	Ердийн горимоор хуралдаж байна.	Цахим санал хураах талаар ярьж байгаа ч одоогоор ямар нэг шийдэлд хүрээгүй бөгөөд үүнийг хурдан зохицуулах амаргүй гэдгийг Конгресс цохон тэмдэглэжээ. Онцгой бүрэн эрх нь Конгресст санал өгөх ердийн горимыг өөрчлөх боломж олгож байна.
32. Австри	Бүртгэгдсэн - 10180 Нас барсан - 128	Ердийн горимоор хуралдаж байна.	Хууль тогтоох байгууллагын үйл ажиллагааг доголдуулахгүй байхыг чухалчилж байгаа бөгөөд дэг өөрчлөх, цахимаар хуралдах санал одоогоор гараагүй байна. Нөхцөл байдалтай уялдуулан парламентын гишүүд, тамгын

			<p>газрын ажилтнуудын аюулгүй байдлыг хангах зарим арга хэмжээ авч байна:</p> <ul style="list-style-type: none"> <li>- Байнгын хороо, нэгдсэн хуралдааны танхимын багтаамж зайг ихэсгэж гишүүд өөр хоорондоо 1 м зайтай суух;</li> <li>- Ажлын өрөөнөөс хуралдааныг видео хэлбэрээр үзэх;</li> <li>- Хуралдаан үргэлжлэх хугацааг багасгах, хэлэлцүүлгийн үед асуулт тавихгүй байх;</li> <li>- Нэн шаардлагатайгаас бусад тохиолдолд Тамгын газрын ажилтнууд гэрээсээ ажиллах зэрэг болно.</li> </ul>
<b>33. Швейцар</b>	Бүртгэгдсэн - 16605 Нас барсан - 433	Хаврын чуулганаа хаасан.	2020.03.15-нд Коронавирусний тархалтын улмаас хаврын чуулганаа хаасан. Зуны чуулган 2020.06.02-19-нд хуралдах хуваарьтай боловч цаг үеийн асуудлаар ойрын хугацаанд ээлжит бус чуулган зарлан хуралдуулахаар шийдвэрлэсэн. Уг хуралдааныг халдварын тархалтаас сэргийлэх зорилгоор Берн хотоос өөр газар хийхээр төлөвлөж байна.
<b>34. Лихтенштейн</b>	Бүртгэгдсэн - 68	хойшлуулсан	Хуралдаан 2020.04.01-нээс эхлэх байсан ч 2020.05.06 хүртэл хойшлуулсан.
<b>35. Польш</b>	Бүртгэгдсэн - 2311 Нас барсан - 33	Зайнаас хуралдаж байна.	2020.03.24-нд Сеймийн дэгийн журамд өөрчлөлт оруулсан бөгөөд түүний дагуу хуралдаанд зөвхөн бүлгийн төлөөллүүд оролцож, бусад гишүүдийг цахимаар оролцох юм.
<b>36. Хорват</b>	Бүртгэгдсэн - 867 Нас барсан - 6	Байршлыг шилжүүлсэн (газар	2020.03.22-нд газар хөдөлсний улмаас хуралдааныг Парламентын ордонд бус түр өөр

		хөдлөлтийн улмаас)	байранд явуулж байна. Хуралдааныг явуулахдаа Эрүүл мэндийн яамнаас өгч буй зөвлөмжийг мөрдөн, гишүүдийг өөр хоорондоо 2 м зайд суулгаж байна. Хуралдаанд нийт гишүүд оролцох боломжгүй тул намын бүлэг тус бүрийг төлөөлж 2 гишүүн оролцож, санал хураалтыг гар өргөх зарчмаар явуулж байна.
<b>37. Албани</b>	Бүртгэгдсэн - 243 Нас барсан - 15	Хуралдааны тоог хязгаарласан. Байнгын хороод зайнаас хуралдаж байна.	Парламентын дарга нь Засгийн газраас авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, шийдвэрийг хууль тогтоох байгууллага ч даган мөрдөх ёстой гэж мэдэгдэв. Нэгдсэн хуралдаанд зөвхөн хуулийн төсөл хэлэлцүүлэх, санал хураах үед гишүүд танхимд цугларах горимоор ажиллаж байна. Байнгын хороодын үйл ажиллагааг цахим хэлбэрт шилжүүлсэн.
<b>38. Болгар</b>	Бүртгэгдсэн - 399 Нас барсан - 8	Түр зогсоосон	2020.03.26-наас онц байдал дуусах хүртэл түр зогсоосон бөгөөд Онц байдлын тухай хууль болон коронавирусний эсрэг авах арга хэмжээний талаар хэлэлцэх зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд хуралдуулахаар шийдвэрлэсэн.
<b>39. Швед</b>	Бүртгэгдсэн - 4435 Нас барсан - 180	Хуралдааны тоог хязгаарласан.	Парламентын дэгийн журамд өөрчлөлт оруулсан бөгөөд Парламент дахь намын бүлгийн дарга нарын шийдвэрээр 2020.03.16-31-ний өдрүүдэд нийт 349 парламентын гишүүнээс зөвхөн 55 гишүүн хуралдаанд оролцох хязгаар тогтоосон.
<b>40. Дани</b>	Бүртгэгдсэн - 2860 Нас барсан - 90	Хуралдааны тоог хязгаарласан.	2020.03.12-нд Парламентын дэгийн хороо хуралдсан бөгөөд парламентын үйл ажиллагааг зогсоохгүй байх талаар шийдвэр гаргасан. Парламент нь зөвхөн

		<p>нэн чухал асуудлыг авч үзэх бөгөөд хууль тогтоомж батлах, хэлэлцүүлгийн явцад холбогдох хороод хуралдах, харьяа сайд нар хороодын хуралд оролцох, мэдээллээр хангах үйл зэрэг ажиллагаа хэвээр үргэлжилнэ. Бусад үйл ажиллагааг Эрүүл мэндийн байгууллагын ерөнхий зааварчилгааны дагуу 2020 оны 4-р сарын 3-ны өдөр хүртэл түр зогсоохоор болсон.</p> <p>Цахимаар хуралдах талаар ямар нэг шийдвэр гараагүй.</p>
--	--	--



## 4. СОНГУУЛЬД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨ

COVID-19 өвчний дэгдэлтийн улмаас дэлхийн олон оронд сонгууль, ард нийтийн санал асуулгыг хойшлуулж байна. Олон улсын IDEA-аас гаргасан сонгуулийн удирдлагын байгууллага, мэдээллийн хэрэгслүүдийн мэдээлж байгаагаар одоогийн сонгуулийн хуваарь, төлөвлөгөөний жагсаалтыг 2020 оны 4 дүгээр сарын 01-ний байдлаар оруулав.<sup>48</sup>

### 4.1. COVID-19-ийн дэгдэлтийн улмаас сонгуулиа хойшлуулсан орнууд

	Улсын нэр	Сонгууль	Сонгууль болох газар	Товлогдсон огноо	Хойшлогдсон байдал
1	Австрали	Орон нутгийн засаг захиргааны сонгууль	Шинэ Өмнөд Уэльсийн	2020 оны 09-р сард	1 жилээр хойшлуулав
2	Австри	Орон нутгийн болон хотын даргын сонгууль	Vorarlberg мужид	2020.03.15	Хойшлуулав
3	АНУ	Ерөнхийлөгчийн анхан шатны сонгууль	15 мужид	2020 оны 03-05-р сард	Хойшлуулав 2020.06.09, 23
4	АНУ	Ерөнхийлөгчийн анхан шатны сонгууль	Баруун Виржина мужид	2020.05.12	Хойшлуулав 2020.06.09
5	АНУ	Ерөнхийлөгчийн анхан шатны сонгууль	Нью Йорк хотод	2020 оны 3-5-р сард	Хойшлуулав 2020.06.23
6	Аргентин	Орон нутгийн сонгууль	Рио Куартогийн Кордован хотод	2020.03.29	Хойшлуулав 2020.09.27
7	Армен	Үндсэн хуулийн шүүхэд өөрчлөлт оруулах тухай референдум		2020.04.05	Хойшлуулав
8	Болив	Ерөнхий сонгууль		2020.02.03	Хойшлуулав

<sup>48</sup> IDEA - <https://www.idea.int/news-media/multimedia-reports/global-overview-covid-19-impact-elections>

9	Бразил	Сенатын нэмэлт сонгууль	Мато Гроссо мужийн	2020.04.28	Хойшлуулав
10	Зимбабве	Дүүргийн зөвлөлийн 16-р тойрогт ээлжит сонгууль	Чиредзи тосгоны	2020.04.04	Хойшлуулав
11	Индонез	Бүс нутгийн сонгууль		2020.09.23	Хойшлуулав
12	Иран	Парламентын сонгуулийн хоёр дахь шатны сонгууль		2020.04.17	Хойшлуулав 2020.09.11
13	Испани	Бүс нутгийн сонгууль	Еускади, Галисиа хотод	2020.04.05	Хойшлуулав
14	Итали	Парламентын суудлын тоог бууруулахаар бүх нийтийн санал асуулга		2020.03.29	Хойшлуулав
15	Их Британи	Бүх нийтийн санал асуулга	Фолклэндийн арлуудад (Их Британийн далайн чанд дахь нутаг дэвсгэр)	2020.03.26	6 сараар хойшлуулав
16	Их Британи	Орон нутгийн сонгууль		2020 оны 5-р сарын эхний долоо хоногт	Хойшлуулав 2021 оны 5-р сар
17	Канад	Хотын ээлжит сонгууль	Викториагийн хотод	2020.04.04	Хойшлуулав
18	Кипр	Киприйн удирдлагын сонгууль		2020.04.26	Хойшлуулав 2020.10.11
19	Колумби	Олон нийтийн зөвлөлийн сонгууль		2020.04.26	Хойшлуулав
20	Кыргыз	Орон нутгийн сонгууль		2020.04.13	Хойшлуулав
21	Латви	Хотын зөвлөлийн орон нутгийн	Рига хот	2020.04.25	Хойшлуулав




		ээлжит сонгууль			
22	Мальдив	Орон нутгийн зөвлөлийн сонгууль		2020.04.04	Хойшлуулав
23	Нигери	Сенатын нөхөн сонгууль	Байелса, Имо, Плато мужид	2020 оны 03-р сард	Хойшлуулав
24	ОХУ	Үндсэн хуулийн бүх нийтийн санал асуулга		2020.04.22	Хойшлуулав
25	Өмнөд Африк	нөхөн сонгууль	Кейп мужийн Жорж хотод	2020.05.13	Хойшлуулав
26	Пакистан			2020 оны 03-р сард	Хойшлуулав
27	Парагвай	Анхан шатны сонгууль		2020.07.12	Хойшлуулав 2020.08.02
28	Парагвай	Орон нутгийн (Хотын) сонгууль		2020.11.08	Хойшлуулав 2020.11.29
29	Перу	Орон нутгийн нэмэлт сонгууль	Аякучо дүүргийн Чипао хотод	2020.03.29	Хойшлуулав
30	Серби	Ерөнхий сонгууль		2020.04.26	Хойшлуулав
31	Сири	Парламентын сонгууль		2020.04.13	Хойшлуулав 2020.05.20
32	Соломон ы арлууд	Тойргуудын сонгууль	Төв Хониара ба Зүүн хойд Гвадалканалы н тойргуудын	2020 оны 06-р сард	Хойшлуулав
33	Тунис	Орон нутгийн сонгууль	Хасси Эль Ферид, Жбенаниа хотод	2020.03.28 -29	Хойшлуулав
34	Франц	Орон нутгийн 2 дахь шатны сонгууль		2020.03.22	Хойшлуулав
35	Хойд Македон и	Парламентын сонгууль		2020.04.12	Хойшлуулав
36	Чили	Үндсэн хуулийн бүх нийтийн санал асуулга		2020.04.26	Хойшлуулав 2020.10.25

9	Бразил	Сенатын нэмэлт сонгууль	Мато Гроссо мужийн	2020.04.28	Хойшлуулав
10	Зимбабве	Дүүргийн зөвлөлийн 16-р тойрогт ээлжит сонгууль	Чиредзи тосгоны	2020.04.04	Хойшлуулав
11	Индонез	Бүс нутгийн сонгууль		2020.09.23	Хойшлуулав
12	Иран	Парламентын сонгуулийн хоёр дахь шатны сонгууль		2020.04.17	Хойшлуулав 2020.09.11
13	Испани	Бүс нутгийн сонгууль	Еускади, Галисиа хотод	2020.04.05	Хойшлуулав
14	Итали	Парламентын суудлын тоог бууруулахаар бүх нийтийн санал асуулга		2020.03.29	Хойшлуулав
15	Их Британи	Бүх нийтийн санал асуулга	Фолклэндийн арлуудад (Их Британийн далайн чанд дахь нутаг дэвсгэр)	2020.03.26	6 сараар хойшлуулав
16	Их Британи	Орон нутгийн сонгууль		2020 оны 5-р сарын эхний долоо хоногт	Хойшлуулав 2021 оны 5-р сар
17	Канад	Хотын ээлжит сонгууль	Викториагийн хотод	2020.04.04	Хойшлуулав
18	Кипр	Киприйн удирдлагын сонгууль		2020.04.26	Хойшлуулав 2020.10.11
19	Колумби	Олон нийтийн зөвлөлийн сонгууль		2020.04.26	Хойшлуулав
20	Кыргыз	Орон нутгийн сонгууль		2020.04.13	Хойшлуулав
21	Латви	Хотын зөвлөлийн орон нутгийн	Рига хот	2020.04.25	Хойшлуулав

37	Швейцар	Холбооны санал хураалт		2020.05.17	Хойшлуулав
38	Швейцар	Орон нутгийн сонгууль	Нойчел, Тицино, Лузерн мужуудад	2020.04.06	Хойшлуулав
39	Шри Ланка	Парламентын сонгууль		2020.04.25	Хойшлуулав
40	Энэтхэг	Парламентын дээд танхим		2020.03.26	Хойшлуулав
41	Этиоп	Парламентын сонгууль		2020.08.29	Хойшлуулав

Зураг1-д **цэнхэр өнгөөр** COVID-19 өвчний дэгдэлтийн улмаас сонгуулиа хойшлуулсан орнуудыг тэмдэглэв.





10	Польш	6 нэмэлт сонгууль		2020.03.22
11	Франц	Орон нутгийн сонгууль		2020.03.15

#### 4.3. COVID-19-ийн дэгдэлтийн улмаас сонгуулиа хойшлуулах талаар хэлэлцэж байгаа орнууд

1. Сингапур
2. Уругвай
3. Доминикан улс
4. Зааны ясан эрэг
5. Эквадор
6. Мексик
7. Румын.

#### 4.4 Сонгуулиа товолсон хугацаандаа зохион байгуулах орнууд

Хүснэгт 4

	Улсын нэр	Сонгууль	Сонгууль болох газар	Товлогдсон огноо
1	Австрали	Хууль тогтоох зөвлөлийн сонгууль	Тасмани	2020.05.30
2	Австрали	Орон нутгийн сонгууль	Квинслэнд	2020.03.29
3	АНУ	Ерөнхийлөгчийн анхан шатны сонгууль	Висконсин, Вайоминг, Аляск, Хавайд	2020.04.04., 07
4	Мали	парламентын хоёр дахь шатны сонгууль		2020.04.19
5	Монгол	Парламентын сонгууль		2020.06.24
6	Өмнөд Солонгос	Парламентын сонгууль		2020.04.15
7	Польш	Ерөнхийлөгчийн сонгууль		2020.05.10
8	Швейцар	Хотын 2 дахь шатны сонгууль	Женев хотод	2020.04.05
9	Шинэ Зеланд	Ерөнхий сонгууль, референдумууд		2020.06.19

#### 4.5. Сонгуулийн үед COVID-19-ийн дэгдэлтээс урьдчилан сэргийлэхээр авсан, эсхүл авах хэмжээ

	Улсын нэр	Сонгууль	Товлогдсон огноо	Тайлбар
1	Австрали	Квинсландын орон нутгийн сонгууль	2020.03.28	Квинслендын Сонгуулийн хороо сонгуулийн өмнө COVID-19-ээс урьдчилан сэргийлэх хамгаалах арга хэмжээний жагсаалтыг нийтэллээ. Австрали зайлшгүй сонгуулийг зохион байгуулна гэж мэдэгдсэн.
2	Австри	Ворарлберг, Штирия дахь орон нутгийн сонгууль	2020.03.15, 2020.03.22	<ul style="list-style-type: none"> <li>• 2020.03.15-нд ‘COVID-19-Law’ нэг өдрийн журам батлав. Энэ хуульд сонгууль гэж заагаагүй боловч олон нийтэд тавигдах хоригийг багтааж, 5-аас дээш хүн хуралдуулахыг хориглосон.</li> <li>• Орон нутгийн 2 сонгууль цуцлагдсан.</li> <li>• Сонгуулийг дахин товлон зарлана.</li> <li>• Сонгуулийг тодорхой хугацаагаар хойшлуулах талаар Австрийн Үндсэн хууль, Сонгуулийн тухай хуульд “Сонгууль эхлэх, үргэлжлэх, дуусгахаас урьдчилан сэргийлэх нөхцөл байдал үүссэн тохиолдолд сонгуулийн удирдлага сонгуулийг сунгаж, дараагийн өдөр хүртэл хойшлуулж болно” гэж заасан байна.</li> </ul>
3	АНУ	Онцгой сонгууль	2020.04.28	Мэрилэнд мужид сонгуулийн удирдлагын байгууллага (EMB) 4-р сарын сүүлээр онцгой сонгууль зохион байгуулахаар төлөвлөж байна. Энэ нь COVID-19-д хариулах ба санал хураалтыг зөвхөн шуудангаар хийнэ. Энэхүү онцгой сонгууль нь орон нутгийн EMB-ийн албан тушаалтнуудад шуудангийн санал хураалтыг АНУ даяар загвар болгон ашиглаж

				болох эсэхийг тодорхойлох туршилтын ажил юм.
4	Герман	Баварийн орон нутгийн сонгууль	2020.03.16	Орон нутгийн сонгуулийн эхний шатны санал хураалтыг санал авах байруудад очиж биечлэн, мөн шуудангаар саналаа өгсөн байна.
5	Израиль	Үндэсний сонгууль	2020.03.04	Хуванцар бүрээсээр хийсэн тусдаа санал авах байр байгуулж, сонгуулийн ажилтнууд гадаадаас буцаж ирснийхээ дараа гэрээс тусгаарлах хяналтад байсан 5,500 гаруй сонгогчдод хамгаалалтын хувцас өмссөн байв.
6	Индонез	Бүс нутгийн сонгууль	2020.09.26	ТББ-ууд нь 03.21-нд Сонгуулийн хорооноос бүс нутгийн сонгуулийг түр зогсоохыг уриалсан байна. Сонгуулийн хороо 03.30-нд хуралдаж, дараагийн алхмуудыг цогцоор нь хэрэгжүүлэхээр болов: сонгуулийг хойшлуулж, ашиглагдаагүй сонгуулийн төсвийг COVID-19 тахлын эсрэг хариу арга хэмжээ авахын тулд бүс нутгийн засгийн газарт хуваарилахаар тохиролцов. Эцэст нь парламент дараагийн чуулганаар хэлэлцүүлж эхлэх хүртэл “Засгийн газрын тогтоол” (“Government Regulation In Lieu of a Law”)-ыг баталсан нь дээрх арга хэмжээний эрх зүйн үндэс болно.
7	Их Британи		2020 оны 5-р сарын эхний долоо хоногт	Сонгуулийн хорооноос парламентад Лондон хотын захирагчийн сонгууль, Английн болон Уэльсийн орон нутгийн сонгууль, 2020.05.07-нд болох бүс нутгийн цагдаа, гэмт хэрэгтэй тэмцэх комиссын гишүүдийн сонгуулийг хойшлуулахыг зөвлөсөн байна. Энэхүү зөвлөгөөг үндэслэн Их Британийн Засгийн газар сонгуулийг 2021.05.06-ыг

				хүртэл хойшлуулах хуулийн төслийг өргөн барив.
8	Өмнөд Солонгос	Парламентын сонгууль	2020.04.15	<ul style="list-style-type: none"> <li>• Сонгогчид санал өгөхөөр гэр, эмнэлгээс гарах боломжтой.</li> <li>• Үндэсний Сонгуулийн Хороо иргэдийн санал авах ажиллагаанд оролцох ёс зүйн дүрмийг боловсруулж байна.</li> <li>• Сонгогч санал авах байранд очихын өмнө гараа угаах, маскаа зүүх, иргэний үнэмлэхээ авчирна.</li> <li>• Сонгогчид санал авах байранд болон түүний гадна хэлэлцүүлэг хийхээс зайлсхийх, бусадтай харилцахдаа зөвлөмжийн дагуу зай барих шаардлагатай.</li> </ul>
9	Шинэ Зеланд	Ерөнхий сонгууль, референдум	2020.09.19	ЕМВ нь санал авах өөр аргыг тодруулж, сонгуулийн товыг өөрчлөх санал гаргасан.





## БРАЗИЛИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ТАНХИМЫН ТОГТООЛ (№14, 2020)

Энэхүү тогтоол нь Төлөөлөгчдийн танхимын коронавирүсний халдвартай холбоотойгоор олон улсын эрүүл мэндийн онцгой нөхцөл байдлын үед чуулганы бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэхэд чиглэсэн онцгой арга хэмжээ болох Алсын зайн хэлэлцүүлгийн системийн (SDR) хамрах хүрээг тодорхойлно.

**1 дүгээр зүйл.** Энэхүү тогтоол нь Төлөөлөгчдийн танхимын чуулганаар асуудлыг хэлэлцэх, санал өгөхөд Алсын зайн хэлэлцүүлгийн системийг ашиглах асуудлыг зохицуулна.

Энэхүү тогтоолд тодорхойлсон зайн санал хураалт болон хэлэлцүүлэгт технологийн шийдлийг ашиглан чуулганы хуралдаанд парламентын гишүүн Танхимд биеэр хүрэлцэн ирэхийг шаардахгүй байна.

**2 дугаар зүйл.** Энэхүү тогтоол нь коронавирүсний халдвартай холбоотойгоор олон улсын эрүүл мэндийн онцгой нөхцөл байдлын үед чуулганы хуралдааныг хуралдуулах Алсын зайн хэлэлцүүлгийн систем (SDR)-ийн ашиглалтыг Төлөөлөгчдийн танхимын Даргын тусгайлан тогтооно.

**§1.**Төлөөлөгчдийн танхимын Дарга Алсын зайн хэлэлцүүлгийн систем (SDR)-ийг ашиглан хуралдахаар шийдвэр гаргасан бол хойшлогдсон байсан чуулганы хуралдааны хэлэлцүүлэг цахимаар явагдана.<sup>50</sup>

**§2.**Чуулган болон танхимын бүтцийн нэгжүүдийн чуулган болон хуралдааныг Эрүүл мэндийн яамнаас гаргасан зөвлөмжид нийцүүлэн явуулах боломжтой болмогц Төлөөлөгчдийн танхимын дарга чуулган, хуралдааныг хуучин байдлаар буюу биеэр хүрэлцэн ирж явуулахыг тогтооно.<sup>51</sup>

**3 дугаар зүйл.** Алсын зайн хэлэлцүүлгийн систем (SDR)-нь нэг, эсхүл түүнээс дээш тооны платформ дээр тулгуурлан парламентын гишүүд хооронд видео болон аудиогоор мэтгэлцэх боломжоор хангахдаа дараах нөхцөлийг хангасан байна.

1. Алсын зайн хэлэлцүүлгийн систем (SDR)-ээр явуулах чуулган нь 1989 оны 9 дүгээр сарын 21-ний 7 дугаар тогтоолоор батлагдсан Төлөөлөгчдийн танхимын дотоод журам 92 бүлгийн I, II болон III-т зааснаас бусад тохиолдолд олон нийтэд нээлттэй байхын сацуу чуулганы хуралдааныг хэвлэл мэдээллийн хэрэгслээр шууд дамжуулна. Хуралдааны аудио болон видеог дараа ашиглах боломжийг бүрдүүлнэ.
2. Санал хураалтын систем нь санал хураалтын үр дүнг нэгтгэж зарлах хүртэл парламентаар тогтоосон нууцлалын зэргийг хадгална.

<sup>50</sup> § 1 If the SDR is actuated by the President of the Chamber of Deputies, the plenary deliberations will be carried out through virtual sessions and as meetings of commissions of the Chamber of Deputies that are suspended.

<sup>51</sup> § 2 The President of the Chamber of Deputies determines that the face-to-face deliberations must be resumed as soon as the displacement of parliaments between Brasília and their States and the sessions and meetings of the organization units of the House are compatible with the recommendations of the Ministry of Health.

3. Санал хураалт дууссаны дараа Алсын зайн хэлэлцүүлгийн систем (SDR)-ээр өгсөн саналыг буцаах боломжгүй байна.
4. SDR-ийн ашигладаг технологийн шийдэл нь интернэтээр парламентын гишүүдийн биометрийн мэдээллийг дамжуулахгүй.
5. Санал хураалтын процесс, саналын үр дүнг нэгтгэх болон үр дүнг зарлах нь холбогдох аюулгүй байдлын протоколын дагуу бүхэлдээ Төлөөлөгчдийн танхимын зохион байгуулалтын хүрээнд явагдана.
6. Хуралдааны видео болон аудио зохион байгуулах шийдэл нь энэхүү тогтоолд заасан шаардлагуудыг хангасан арилжааны платформуудыг ашиглаж болно.
7. SDR нь чуулганы хуралдаанд аудио болон видеогоор оролцох, санал өгөхөд IOS, Android үйлдлийн систем ашигладаг ухаалаг утсыг ашиглаж болно.
8. Чуулганы хуралдаанд аудио болон видео оролцоо нь Төлөөлөгчдийн танхимын хүлээн зөвшөөрсөн платформоор дамжуулан явагдаж, интернетийн сүлжээнд холбогдсон байх бөгөөд санал хураалтын процесст ухаалаг гар утсаар оролцоно.
9. SDR нь санал хураалтад оролцож байгаа парламентын гишүүдэд хэрэглэгдэх төхөөрөмжийг таниулан баталгаажуулах 2 үе шат бүхий баталгаажуулалт шаардана.
10. SDR нь бүх парламентын гишүүд болон Ерөнхий нарийн бичгийн дарга нар нэгэн зэрэг нэвтрэх боломжоор хангах бөгөөд Төлөөлөгчдийн танхимын даргын шууд удирдлага дор хуралдаанд оролцоно.
11. SDR ашиглаж буй чуулганы хуралдааны үед Инноваци, мэдээллийн технологийн газрын даргын хариуцлага дор байх ба тэрээр тасралтгүй ажиллагааг хангана. Хэлэлцүүлгийн платформуудын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар парламентын гишүүд болон даргалагч нарт зориулсан дуудлагын төв ажиллана.

**4 дүгээр зүйл.** SDR-аар явагдах чуулган нь Төлөөлөгчдийн танхимын онцгой /ээлжит бус/ зөвлөлдөх хуралдаан гэж үзэх бөгөөд хуралдаан цахим орчинд явагдсан талаарх мэдээллийг тодорхой тэмдэглэнэ.

**§1.** SDR-аар явагдах чуулган нь товлогдсоноос бусад тохиолдолд хуралдахаар бол хамгийн багадаа 24 цагийн өмнө мэдэгдэнэ.

**§2.** SDR-аар хуралдсан хуралдаанууд короновирустай холбоотой олон улсын эрүүл мэндийн онцгой нөхцөлтэй холбоотой асуудлыг нэн даруй хэлэлцэнэ.

**§3.** Танхимын гишүүдийн 2/3, Засгийн газрын тэргүүлэгчид, олонх, цөөнх болон сөрөг хүчний төлөөллийг оролцуулсан удирдагч нарын дэмжсэн асуудлыг Төлөөлөгчдийн танхимын дотоод журмын 155-д заасны дагуу нэн яаралтай хэлэлцүүлэгт оруулах журмаар хэлэлцэх асуудлын тов, дараалалд ороогүй байсан тохиолдолд гаргасан хүсэлтийн дагуу тов, дараалалд оруулж, тэдгээр асуудлын тухайд хэлэлцэх асуудлаас хасах, хэлэлцүүлэг, эсхүл санал хураалтыг хойшлуулах, тогтоосон процессын дагуу томъёолол тус бүрээр хэлэлцүүлэг

болон санал хураалт явуулах, завсарлага авах зэрэг Төлөөлөгчдийн танхимын дотоод журмын 120.4-т заасан шаардлагууд тавигдахгүй.<sup>52</sup>

**§4.** SDR-аар явагдах хуралдааны хэлэлцэх асуудал нь бол энэхүү тогтоолын 3 дугаар зүйлийн 3.3.-т заасан асуудалд хамаарах бөгөөд хэлэлцэх асуудлын дүгнэлтэнд хугацаа шаардлагатай бол Төлөөлөгчдийн танхимын дарга хуралдааны хугацааг сунгаж болно.

**§5.** Энэхүү 3 дугаар зүйд заасан шаардлагад нийцээгүй асуудлыг оруулах тохиолдолд журамд заагдсан бүх үйл ажиллагааны шаардлагуудад нийцүүлэх, мөн хуралдааны үргэлжлэх хугацааг хязгаарлана. 1989 оны 9 дүгээр сарын 21-ний өдрийн 17 дугаар тогтоолоор баталсан Төлөөлөгчдийн танхимын дотоод журмын 72, хуульд зааснаар 1 цагаар сунгаж болно.


**5 дугаар зүйл.** Парламентын гишүүн, эсхүл төлөөлөгч нь гуравдагч этгээдэд өөрийн хувийн нууц үг, эсхүл бүртгүүлсэн төхөөрөмжөөр саналаа бүртгүүлэх боломжтой байх нь хөгжлийн бэрхшээлтэй парламентын гишүүн уг системийг зохих ёсоор ашиглахад зайлшгүй шаардлагатай нөхцөл байхаас бусад тохиолдолд Холбооны Үндсэн Хуулийн 55.2-т заасны дагуу тэдгээрийн үйл ажиллагаа, үйлдэл парламентын журамд нийцэхгүй байна.

**6 дугаар зүйл.** SDR-ийг ашиглаж эхлэхээс өмнө Товчооны Ерөнхий нарийн бичгийн даргаар батлуулах ёстой.


**7 дугаар зүйл.** Төлөөлөгчдийн танхимын хуулийн товчоо энэ тогтоолыг 72 цагийн дотор батламжилна.

**8 дугаар зүйл.** Энэхүү тогтоол нь хэвлэгдсэн өдрөөс хойш хүчин төгөлдөр болно.

Төлөөлөгчдийн танхим, 3 дугаар сарын 17, 2020



<sup>52</sup> § 3<sup>o</sup> Subjects that have the favorable opinion of Leaders representing 2/3 (two thirds) of the members of the House and of the Leaders of the Government, the Majority, the Minority and the Opposition may, upon request, be included in the agenda already in the regime of urgency referred to in art. 155 of the Internal Regulations of the Chamber of Deputies, if they are not yet processed in this regime, and, in relation to them, there will be no requirements for removal of the agenda, postponement of the discussion or vote, of discussion or voting in installments or by a determined process, nor requirements of simple detachment or breach of interstice for request for verification of symbolic voting, being ensured the right to submit outstanding requests for bench and Plenary amendments, subject to the provisions of § 4 of art. 120 of the Internal Regulations of the Chamber of Deputies, approved by Resolution No. 17, of September 21, 1989.

 Улсын Их Хурлын Тамгын газар. Монгол  
Улс 14201 Улаанбаатар хот, Сүхбаатар  
дүүрэг, Жанжин Д.Сүхбаатарын талбай 1,  
Төрийн ордон.

 [prs@parliament.mn](mailto:prs@parliament.mn)

 976-51-260443